



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • II • № 28

*Банкны
хогжил 95 жил*

Д.ГАН-ОЧИР:
ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ
ЗОХИСТОЙ
ТҮВШИНД ХҮРСНЭЭР
САНХҮҮГИЙН
ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛНА

ДОЛЛАРААС
ТӨГРӨГТЭЙ
БОЛСОН ТҮҮХ

ГЕОПОЛИТИКИЙН
ЗАРИМ АСУУДАЛД
ТӨВ БАНКУУДЫН
БОДЛОГЫН ХҮҮ



Зургийн тайлбар: Худалдаа аж үйлдвэрийн банк анх байрлаж байв. 1924 он
(Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн зүүн өнцөг)



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



•ТИНК БАНК 2019-МӨНГӨ САНХ



Г.ЗАНДАНШАТАР

Улсын Их Хурлын дарга

Цаашид бид УИХ-ыг популизмын талбар, хэрүүлийн танхим болгож болохгүй гэж үзэж байгаа. Иймээс УИХ-ын дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж, нотолгоонд суурилсан парламентын мэтгэлцээнийг өрнүүлэх замаар хууль тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг дэг буюу олон улсын жишигт нийцүүлэхийг зорьж байна.



Д.БАТТӨМӨР

УИХ-ын гишүүн

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийн хэрэгжилтэд анхаарах, худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага бий бөгөөд үүнд төрийн байгууллагууд судалгааны институцийг бэхжүүлэн үйл ажиллагааг эрчимжүүлж, бодлого боловсруулах үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж байх нь чухал ач холбогдолтой.



С.ДЭМБЭРЭЛ

Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал

Засаглал, институцийн реформыг 2019 онд багтаан хэрэгжүүлэх шаардлага байгаа бөгөөд төр болон зах зээлийн харилцаанд чанарын эргэлт хийх зайлшгүй хэрэгцээ бий.

САНХҮҮГИЙН ОРЧИН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төрийн ордон 2019.02.22



Р.АМАРЖАРГАЛ

Эдийн засагч

Гадаадын банк аливаа улс оронд үйл ажиллагаа явуулах асуудлыг онолын түвшинд эергээр тайлбарладаг хэдий ч Монгол Улсын онцлогийг харгалзан үзвэл санхүүгийн зах зээл дөнгөж хөл дээрээ зогсох гэж байгаа энэ үед гадны банк орж ирэх нь боломж үүсгэхээсээ илүү эрсдэл дагуулах бөгөөд гадны банкны манайд нэвтрэх хэлбэрүүдэд түлхүү анхаарч, тодорхой зохицуулалт хийх хэрэгтэй.



Б.БАЯРДАВАА

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал

Бодит секторын хувьд, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, ингэснээр иргэдийн орлогыг үнийн дарамтгүйгээр өсгөх, инфляцийн дарамтгүйгээр бодит орлогын өсөлтийг бий болгох, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтууд шаардлагатай байна.



А.ЭНХЖИН

Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал

Монгол Улсын нийт экспортын 90 орчим хувийг эрдэс баялгийн экспорт эзэлдэг тул валютын нийлүүлэлт нь цөөн тооны аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байдаг онцлогтой. Харин валютын эрэлт нь олон төрлийн оролцогчийн нөлөөтэй байдаг.

Үргэлжлэл: 16 дугаар нүүрт

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Арилжааны банкуудын ТУЗ-ийн хараат бус гишүүдтэй санал солилцох уулзалт хийв

5

Ярилцлага:

ХУУДАС

Д.Ган-Очир: Хэрэглээний зээлийн өсөлт зохистой түвшинд хүрснээр санхүүгийн эрсдэлийг бууруулна

7

Байр суурь:

ХУУДАС

Хэрэглээний зээлийг яагаад хязгаарлах шаардлагатай вэ?

10

Индэр:

ХУУДАС

“Тинкбанк 2019-мөнгө, санхүүгийн орчин” хэлэлцүүлгийг нээж Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы хэлсэн үг

13

Мөнгөн**тэмдэгтийн түүх:**

ХУУДАС

Бэрх хааны мөнгөн зоос 1257 - 1267 он

15

Нийтлэл:

ХУУДАС

Дотоодын үйлдвэрлэлийг сэргээж, мөнгө санхүүгийн орчныг тогтворжуулна

16

Ярилцлага:

ХУУДАС

Төв банк удаан хугацаанд алдагдалтай ажиллах нь үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэлтэй

22

Асуулт, хариулт

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2019.02.27)

28

Банкир:

ХУУДАС

Жероме Пауэл ба Холбооны Нөөцийн банкны хараат бус байдал

32

Дэлхийн үйл явдал:

ХУУДАС

Давос 2019 юу хэлэлцэв?

36

Судалгаа:

ХУУДАС

Геополитикийн зарим асуудалд төв банкуудын бодлогын хүүний нөлөөлөл

38

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Санхүүгийн луйвраас болгоомжил: Үнэгүй бяслаг хавханд л бий

41

Арилжааны банкуудын ТУЗ-ийн хараат бус гишүүдтэй санал солилцох уулзалт хийв

2019.02.14

Монгол Улсад банк, санхүүгийн салбар үүсэж, хөгжсөний 95 жилийн ойг угтан зохион байгуулж буй “Банкны хөгжил -95 жил” аяны хүрээнд Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгээс арилжааны банкуудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд мэдээлэл өгөх, санал солилцох уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар арилжааны банкуудын ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зүгээс гарсан саналуудыг холбогдох газруудад хүргүүлж, цаашид ТУЗ-ийн хараат бус гишүүдийн Монголбанкт хамтран ажиллах уялдаа холбоог өргөжүүлэх шаардлагатай байгааг онцоллоо.



“Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяны тайлан гарлаа

2019.02.15



Монголбанкнаас 2018 оны 10 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх 2 сарын хугацаанд “Цахим эринд цахим төлбөр тооцоо” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, Монгол Улс дахь төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ирээдүйн хөгжлийн талаар олон нийтэд тайлбарлан сурталчлах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.

Санхүүгийн боловсрол олгох сургагч багш нарын сургалт Төв аймагт зохион байгууллаа

2019.02.20

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалтыг Төв аймагт 19-21-ний өдөр амжилттай зохион байгуулагдав. Сургалтад тус аймгийн 27 сумын БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвийн 30 багш хамрагдсан бөгөөд тайлбарлан сурталчлах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.



“Дэлхийн мөнгөний 7 хоног”-ийг манай улс тэмдэглэлээ

2019.02.22



Дэлхийн улс орнууд жил бүрийн хавар залуучуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр “Global Money Week” буюу “Дэлхийн мөнгөний долоо хоног”-ийг зохион байгуулдаг уламжлалтай билээ. Энэ хүрээнд Монголбанк “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Цэцээ Гүн Ротаракт болон “Улаанбаатар” Ротаракт клубтэй хамтран 2-р сарын 20-ний “Learn, Save, Earn” лекцийг амжилттай зохион байгууллаа. Энэхүү лекцэд 200 гаруй залуучууд цугларан банкны хөгжил болон хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгээ тэлэхийн зэрэгцээ Монгол Улсын “Эрдэнэсийн сан”-тай танилцсан юм.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдлаа

2019.02.20

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2019 оны I улирлын ээлжит хуралдаан Санхүүгийн зохицуулах хорооны хурлын танхимд 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр боллоо. Тус хуралдаанаар Санхүүгийн мэдээллийн албаны 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэлтэй Зөвлөлийн гишүүд танилцаж, санал солилцлоо.



“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталлаа

2019.02.25



Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16.1.1, 16.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталлаа.

Банкны харилцагчидтай үулзалт хийж, гадаад төлбөрийн гүйлгээ хийхэд анхаарах зарим асуудлыг танилцууллаа

2019.02.28

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон Монголын банкны холбоо хамтран “Ам.долларын шилжүүлэг ба олон улсын байгууллагуудын шаардлага” сэдэвт, банкны харилцагчдад зориулсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр гадаад төлбөр тооцоонд нэмэлт асуулга, тодруулга авах зэрэг хүндрэл ихээхэн гарах болсныг онцолж, банкны зүгээс шаардсан баримт бичгийг тухай бүр гаргаж өгөх нь төлбөр тооцоог цаг алдалгүй хийхэд дөхөмтэйг онцоллоо. Цаашид Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээг ахиулах чиглэлээр УИХ, Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг олон нийтэд таниулах шат дараатай арга хэмжээг авахаар болов.





Д.ГАН-ОЧИР: ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ ЗОХИСТОЙ ТҮВШИНД ХҮРСНЭЭР САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛНА

Монголбанкны Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИРТОЙ** ярилцлаа.

**2018 ОНД МОНГОЛ
УЛСАД ОРЖ ИРСЭН
ГАДААДЫН ШУУД
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭМЖЭЭ 1 ТЭРБУМ 867
САЯ АМ.ДОЛЛАРТ ХҮРСЭН
БАЙНА. ҮҮНИЙ ДИЙЛЭНХ НЬ
УУЛ УУРХАЙН САЛБАР, ТЭР
ДУНДАА МЕГА ТӨСЛҮҮДИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД
ТӨВЛӨРСӨН. ТЭГЭХЭЭР
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ӨСЧ
БАЙГАА Ч НЭГ САЛБАРТ
ХЭТ ИХ ТӨВЛӨРӨХ НЬ ЯМАР
ЭРСДЭЛ ДАГУУЛЖ БОЛОХ
ВЭ?**

Эрсдэлийг дурдахаас өмнө төлбөрийн тэнцлийн ерөнхий дүр зургийг авч үзье. 2018 оны төлбөрийг тэнцлийн алдагдал 141.2 сая ам.доллар байна. Энэ алдагдлыг бий болгож байгаа гол хүчин зүйл нь урсгал тэнцлийн алдагдал юм.

Энэ нь 1.9 орчим тэрбум ам.доллар. Үүнтэй тэнцүү хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн нь гадаад валютын захыг тогтвортой байлгах, гадаад валютын улсын нөөцийг өсгөхөд чухал нөлөө үзүүлсэн. Гэхдээ 1.9 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бүтцээр нь задалж, зөв ойлгох хэрэгтэй. Үүнийг дотор нь, мега болон мега бус төслүүдэд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж хоёр хувааж болно. Мега төслүүдэд 1.75 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирсэн бол 150 орчим сая ам.доллар нь уул уурхайн мега бус төслүүдэд зориулсан хөрөнгө оруулалт юм. Мега төслүүдэд орж ирж байгаа 1.75 тэрбум ам.долларыг дотор нь задлаад үзвэл 300 орчим сая ам.доллар нь толгой компаниас тухайн мега төсөлд өгсөн зээлийнх нь хуримтлагдсан хүү байгаа

юм. Тэгэхээр нийт 1.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг 300 сая ам.доллараар цэвэрлээд харвал 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт биетээр орж ирсэн байна. Үүнээс 150 орчим сая ам.доллар нь уул уурхайн мега бус төслүүдэд. Үлдэж байгаа 1 тэрбум 450 орчим сая ам.доллар нь мега төслүүдэд орж ирсэн хөрөнгө оруулалт. Мега төсөлд орж ирсэн хөрөнгө оруулалтыг дахиад дотор нь ангилж үзвэл, зээл, зээлийн бус гэж ангилна. Үүний 50 орчим хувь нь зээлээр орж ирсэн хөрөнгө оруулалт бол үлдсэн нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хэлбэртэйгээр орж ирсэн. Мэдээж гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж байгаа нь эдийн засгийн идэвхжилийг дэмжиж, валютын захын тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөө үзүүлж байгаа. Гэхдээ бүтцээр нь аваад үзвэл зээл багагүй дүнг эзэлж

байгаа юм. Тухайлбал, зээл, зээлийн хүүний төлбөрүүд 1 тэрбум орчим ам.долларыг бүрдүүлсэн. Тэгэхээр цаашдаа үүнд хүүний төлбөрүүд гарна. Өөрөөр хэлбэл, дээрх 1 тэрбум ам.доллар нь Монгол Улсын гадаад өрийг өсгөсөн гэсэн үг. Гадаад өр маань гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа. Иймд анхаарах зүйл нь гадаадын шууд хөрөнгө оруулалт богино хугацаанд ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилтийг дэмжихэд чухал хэдий ч өрийн хэмжээг өсгөж байна. Тэгэхээр өөрөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах нь чухал. Тухайн авсан зээлээсээ илүү үр ашигтай, орлого олж ирэх зүйлд зарцуулах нь чухал. Тэгэхгүй бол дунд, урт хугацаандаа эргээд л эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгох эрсдэлтэй юм.

**ДЭЛХИЙН БАНКНААС
ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ ГЭСЭН
ЗӨВЛӨМЖИЙГ ӨГЧ БАЙСАН.
МОНГОЛБАНКНЫ ЗҮГЭЭС
ЭНЭ ЧИГЛЭЛД ХЭРХЭН
АЖИЛЛАДАГ ВЭ?**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өөрөө онцлогтой. Нэгдүгээрт, тухайн улсын эрсдэлийг бүхэлд нь харж байж орж ирэх эсэх нь тодорхойлогддог. Хоёрдугаарт, тухайн улс дотроо эдийн засгийн ямар салбар нь эрсдэл багатай вэ, хөрөнгө оруулахад таатай салбар нь аль вэ гэдгийг нягталж, эрсдэлийг давах хэмжээний өгөөжтэй салбар хаана байгааг харна. Монголын эдийн засгийн өнөөгийн бүтэц, бэлэн байгаа баялаг, онцлогийг харахаар яах аргагүй уул уурхайн салбар л хөрөнгө оруулагчдын нүдэнд тусч байгаа. Гэхдээ том зургаараа

эдийн засгийн төрөлжилтийг бий болгох зайлшгүй шаардлагатай. Эдийн засгийг төрөлжүүлэхэд эх үүсвэр хэрэгтэй. Эх үүсвэр нь гадаад болон дотоодоос бий болох боломжтой. Дотоод эх үүсвэрийн хувьд банкуудын зээлжүүлэлт болон хөрөнгийн зах зээл дээр бий болж буй IPO болон бусад хөрөнгө оруулалтууд. Монголын хувьд банк төвтэй санхүүгийн системтэй учраас банкны салбараас гарч байгаа зээлийг эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарт чиглүүлэх нь чухал. Монголбанкнаас хэрэгжүүлж эхэлсэн макро зохистой бодлогын арга хэмжээнүүд нь энэ зорилт руу хүргэхэд тодорхой түвшинд нөлөөлнө. Харин гадаад эх үүсвэрийн хувьд Монгол Улсын Засгийн газар буюу төр өөрийн тодорхой стратегия хөрөнгө оруулагчдад зарлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын газрын зураг гэдэг зүйлийг гаргаж ирээд, уг газрын зургийн дагуу бид дунд, урт хугацаандаа энэ салбарыг түлхүү хөгжүүлнэ, үүний тулд төрийн зүгээс ийм дэмжлэг үзүүлнэ, ингэснээр өгөөж ингэж нэмэгдэнэ гэдгийг харуулах шаардлагатай. Тэгэхээр хувийн хэвшил энэ салбарт хөрөнгө оруулснаар ийм үр дүнд хүрнэ гэдэг том газрын зургаа гаргаж ирж байж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирнэ. Түүнээс биш дан ганц хувийн сектор энэ бүх эрсдэлийг үүрч, хөрөнгө оруулалт татна гэдэг хэцүү л дээ.

**2018 ОНЫ СҮҮЛЭЭР
МОНГОЛБАНКНААС
БОДЛОГЫН ШИЙДВЭР
ГАРГАЖ, ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛИЙГ ХЯЗГААРЛАСАН.
ЭНЭ НЬ ТУХАЙН ҮЕДЭЭ
ДОТООДЫН ЭДИЙН
ЗАСАГТ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ,**

**НИЙЛҮҮЛЭЛТЭД ТОДОРХОЙ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ БАЙСАН.
ТҮҮНЭЭС ХОЙШ БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙН ҮР НӨЛӨӨ
ХЭРХЭН ХАРАГДАЖ БАЙНА
ВЭ, ЗЭЭЛ ХУМИГДСАНААР
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭЛЭЛТЭД
НӨЛӨӨ ҮЗҮҮЛСЭН ҮҮ?**

Макро зохистой бодлогын шийдвэрийн хүрээнд хэрэглээний зээлийг хязгаарлах хоёр шаттай арга хэмжээ авсан. Эхлээд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох шийдвэрийг 2018 оны 6 дугаар сард гаргасан. Үүний дараа иргэд сарын төлөлтөө багасгахын тулд илүү урт хугацаатай зээл авах эрсдэл бий болсон. Тийм учраас есдүгээр сард хэрэглээний зээлийн хугацааг дээд хязгаарыг 30 сараар хязгаарлах шийдвэрийг гаргасан. Эдийн засгийн шинжлэх ухааны хувьд бид өрхийн өрийг бий болгохгүй байх, санхүүгийн эрсдэлийг бууруулах замаар ард иргэдийнхээ амьжиргааг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс эдгээр арга хэмжээг авсан юм. Гэтэл ард иргэдийн хувьд тухайн хязгаарлалт үйлчилж эхлэхээс өмнө илүү ихээр зээл авах эрмэлзэл өндөр байлаа. Улмаар 9-12 дугаар сард хэрэглээний зээл маш хурдтайгаар өсөх үр дагаврыг бий болгосон. Бидний хувьд макро зохистой бодлогын арга хэмжээг гэнэт хэрэгжүүлбэл, хүмүүсийн ирээдүйн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн. Мөн 2019 оны эхнээс төрийн албан хаагчдын цалин нэмэгдэж байгаа. Энэхүү орлогын өсөлттэй нийцүүлж, шилжилтийг аажмаар хийх нь зүйтэй гэж үзсэн. Гэтэл энэхүү хязгаарлалт хэрэгжиж эхлэхээс өмнө хүмүүс зээлээ маш хурдацтайгаар тэлэх үйл явц

ажиглагдсан. Гэхдээ бид энэхүү зээлийн тэлэлт нь санхүүгийн том эрсдэлийг богино хугацаанд бий болгохгүй гэж үзэж байгаа. Тэр утгаараа өрхийн хэрэглээ өслөө. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ өсөхийн хэрээр эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулж байгаа. 2018 оны хувьд эдийн засаг, зээл тэлэлттэй, өрхүүд санхүүгийн хэрэгцээгээ хангасан он болж өндөрлөлөө гэж дүгнэж байна.

**МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ХОРООНЫ ЗҮГЭЭС
ЭНЭ ЧИГЛЭЛД ЯМАР
ШИЙДВЭРҮҮД ГАРГАХ ВЭ.
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ХОРООНООС ЭНЭ ОНД
ГАРГАХ ШИЙДВЭРҮҮД ЭДИЙН
ЗАСАГТ ЯМАР НӨЛӨӨЛӨЛ
ҮЗҮҮЛЭХ БОЛ?**

Сая дурдсан макро зохистой бодлогын арга хэмжээнүүд 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж байгаа. Тэгэхээр хэрэглээний зээлийн өсөлт зохистой түвшинд хүрч, буурна гэж үзэж байна. Зээлийн өсөлт зохистой түвшинд хүрэх нь нэгдүгээрт, санхүүгийн эрсдэлийг бууруулж байгаа, хоёрдугаарт макро болон санхүүгийн тогтворгүй байдал бий болохоос сэргийлж байгаа юм. Мөнгөний бодлогын хороо энэ оны 3 дугаар сард ээлжит хурлаа хийнэ. Хороо нь бие даасан статустай 6 гишүүнээс бүрдэж байгаа. Мэргэжлийн зүгээс бид бүхний харж байгаагаар мөнгөний

бодлогын шийдвэрт харгалзан үзэх гол хүчин зүйл нь инфляци, түүний өрнөл байна. Энэ оны төсвийн тэлэлт, цалин тэтгэврийн өсөлтүүд нь инфляци руу хэр шилжих вэ гэдэг дээр нэлээд анхаарал хандуулах байх. Мөн бидний өмнө өнгөрсөн оны хоёрдугаар хагасаас бий болсон нэг эрсдэл нь дэлхийн худалдааны дайн, түүний дэлхийн зах зээл дэх түүхий эдүүдийн үнэд үзүүлэх нөлөө байна. Тэгэхээр төлбөрийн тэнцэл, түүний дотоодын валютын захад үзүүлэх нөлөөг зайлшгүй авч үзэх ёстой. Зээлийн өсөлтийн 2019 оны хувьд нэг их өндөр түвшинд хүрэхгүй байх.

**ДОТООДЫН ХҮЧИН ЗҮЙЛС
ИЙМ БАЙНА. ТЭГВЭЛ
ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСИЙН
НӨЛӨӨЛӨЛ 2019 ОНД
МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ
ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?**

Монголбанкн дээр хийгдсэн судалгаагаар Монголын эдийн засаг дахь хэлбэлзэл, өөрчлөлтийн бараг 50 орчим хувь нь гадаад хүчин зүйлстэй холбоотой гэсэн үр дүн гардаг. Үүн дотроо задалж үзвэл Хятадын эдийн засгийн өөрчлөлт чухал нөлөөтэй. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүхий эдийн эрэлт буюу хилээр гарч байгаа биет хэмжээ, түүний гадаад зах зээл дэх үнийн өөрчлөлт гэсэн дөрвөн хүчин зүйл байгаа. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт 7 хувь байлаа гэхэд 3-3.5 хувь нь дээрх хүчин зүйлстэй холбоотой. Тэр

утгаараа бид гадаад зах зээлийг маш анхааралтай ажиглаж байдаг. Тэгэхээр таны асууснаар гадаад зах зээлтэй холбоотой нөлөө гэвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухайд мега төслүүдэд дийлэнх нь орж ирж байгаа. Энэ маань тогтвортой үргэлжилбэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас орж ирэх эрсдэл буурна. Бидэнд байгаа мэдээллээр мега төслүүд 1-1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг ирэх 2 жилд оруулж ирнэ. Тэгэхээр гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл харьцангуй бага. Харин гол эрсдэл нь экспорт, импорт хоёр дээр гарч ирдэг. Экспортын тухайд Хятадын эдийн засгийн идэвхжил саарч байна. Ерөнхийдөө 2019 онд 6 орчим хувьтай буюу өнгөрсөн оны гүйцэтгэлээсээ буурахгүй байх тохиолдолд Монголын хувьд 2018 онд бий болсон эдийн засгийн өсөлт хангагдах нэг хүчин зүйл болно. Харин түүхий эдийн үнэ асуултын тэмдэг хэвээр байна. Яагаад гэвэл дэлхийн худалдааны дайн болон Хятадын Засгийн газраас байгаль орчны бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 2019 онд хэр идэвхтэй байх нь түүхий эдийн эрэлт болон үнэд томоохон нөлөө үзүүлнэ. Тэгэхээр бид бүхэн бодлогын арга хэмжээндээ дэлхийн зах зээл дээр гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүр харгалзан үзэж, тусгах болно.

Ярилцсанд баярлалаа.

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙГ ЯАГААД ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Монголбанкнаас макро зохистой бодлогын хүрээнд хэрэглээний зээлд өр орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалт тавьж өгсөн. Тодруулбал, 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа 70 хувиас хэтрэхгүй байх, хугацааны хувьд 30 хүртэлх сар байхаар зохицуулсан билээ. Ийнхүү хэрэглээний зээлийг хязгаарласнаар иргэдийг өрийн дарамтанд орохоос урьдчилан сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үр дүнгээ өгөх юм.



Эдийн засагч
Ч.ХАШЧУЛУУН

Өрхийн худалдан авах чадвар 2015, 2016 онд нэлээд буурсан. Үүнийг тухайн үеийн хэрэглэгчийн итгэлийн индексийн үзүүлэлтүүд ч харуулж байсан. 2017 оноос эдийн засаг сэргэж эхлэхэд хүмүүсийн худалдан авалт нэмэгдсэн. Гэхдээ худалдан авалтынхаа дийлэнхийг зээлээр, тэр дундаа цалингийн зээлээр санхүүжүүлсэн байдаг. Хэрэглээний зээлийн энэ их өсөлт импортыг нэмэгдүүлж, валютын ханшид тодорхой хэмжээний дарамт учруулах болсон. Нөгөөтэйгүүр зээл өсөх энэ хандлага нь иргэдийн хувьд өрийн дарамтыг нэмэгдүүлж, хуримтлал үүсгэх боломж, нөхцөлийг хязгаарласнаар дунд хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад ч хүндрэл учруулах эрсдэлтэй байсан. Тийм учраас хэтэрхий эрсдэлтэй байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, валютын ханшийн огцом хэлбэлзлээс хамгаалах арга хэмжээ авах шаардлага үүсээд байсан бөгөөд ОУВС-ийн зүгээс ч бас энэ талаар тодорхой зөвлөмж өгч байсан. Монголбанкны зүгээс хэрэглээний зээлийг хязгаарлах чиглэлийн арга хэмжээнүүд авч, хэрэгжүүлсний үр дүнд иргэдийн худалдан авах чадвар аажмаар сайжрах хүлээлттэй байна.



Эдийн засагч
Ж.ДЭЛГЭРСАЙХАН

Монголбанкны зүгээс макро зохистой бодлого нэрийн дор хэрэглээний зээл, өрхийн өр, орлогын харьцааны дээд хэмжээг тогтоосон нь цаг үеэ олсон зөв шийдвэр гэж би хувьдаа үзэж байгаа. 2016 оноос хойш эдийн засгийн өсөлт нэмэгдсэн, иргэдийн орлого өссөн, эдийн засаг дахь иргэдийн болон бусад талуудын хүлээлт өндөр болсон энэ үед хэрэглээний санхүүжилтийг хязгаарлах нь олон давуу талтай. Энэ хүрээнд нэгдүгээрт, хэрэглээний хэт өсөлтөөр дамжсан эдийн засгийн халалтыг хязгаарлах, хоёрдугаарт, хэрэглээнд хэт тулгуурласан эдийн засгийн мөнгөн урсгалыг багасгаж сүүлийн жилүүдэд зогсонги байсан бизнесийн зээлийн өсөлтийг дэмжих, гуравдугаарт, ипотекийн зээл болон бусад шалтгаанаар сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн өрхийн өрийн дарамтыг хязгаарлаж эрсдэлийг бууруулах зэрэг олон давуу тал бий болох боломжтой гэж үзэж байна. Бодлогын энэ арга хэрэгслийн өөр нэг агуулгын чухал ач холбогдол нь иргэдийн хэрэглээнд хандах хандлага сонголтыг илүү ухамсартай зөв сонголт болгоход хүчтэй нөлөөлнө. Учир нь иргэдийн хувьд томоохон шийдвэр гаргалтыг харьцангуй сэтгэлийн хөөрлөөр тооцоо судалгаагүй хийснээр зохисгүй хэрэглээ болон өрийн дарамтад орох эрсдэл байсаар байна.



Эдийн засагч
Б.ДӨЛГӨӨН

Өнөөдрийн нөхцөлд хэт их өсөөд байгаа хэрэглээний зээлийг бодлогын түвшинд хэр багасгаж, танаж чадах вэ гэдгээс 2020, 2021 онд ирж болзошгүй хямралыг амжилттай даван туулах эсэх нь хамаарна. Сүүлийн 2 жилд өрхийн зээлийн хэмжээ огцом нэмэгдсэн. Зээл авсан хүмүүсийн мэдээллийг шүүж үзвэл нийт орлогынхоо 60-70 хувийг зээлдээ төлж байна гэсэн тоо бий. Энэ юу гэсэн үг вэ гэхээр эдийн засаг эргээд ямар нэгэн байдлаар хямрахад өрх гэрүүд бэлтгэлтэй биш байна. 2018 онд тодорхой бодлого хэрэгжүүлсний үр дүнд 2019 оноос банкнаас иргэдэд гарах хэрэглээний зээлүүд хумигдах байх.



Эдийн засагч
Б.ТҮВШИНТӨГС

Сүүлийн 10 жилээр аваад үзэхэд банкуудын зээлийн багцад гарсан томоохон өөрчлөлт бол хэрэглээний зээл томоохон хувийг эзлэх болсон явдал. Одоогийн байдлаар нийт зээлийн 52 хувийг эзэлж байгаа нь үүнийг харуулж байна. Энэ хандлага цааш үргэлжлэх нь ихээхэн эрсдэл дагуулна. Учир нь манай нийгэм хадгалж хуримтлуулдаг биш харин ч хэрэглээг чухалчилдаг нийгэм болж төлөвших талтай. Хэдийгээр хуримтлуулах эсэх нь хувь хүмүүсийн зан үйлдэлтэй холбоотой боловч 2008/2009 оны санхүүгийн хямрал хэрэглээнд суурилсан тогтолцоо нь эрсдэл өндөртэй, санхүүгийн зах зээл нь гүнзгий хямралд өртөмтгий болохыг харуулсан. Тийм учраас, хэрэглээний зээлийг хязгаарлах бодлогын нөлөөг өрх гэр дээр аваад үзвэл хуримтлал бий болгохыг нь дэмжиж байгаад гол ач холбогдол нь оршиж байгаа. Өөрөөр хэлбэл, энэхүү арга хэрэгсэл нь урт хугацаандаа эдийн засгийн болоод санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байгаа гэсэн үг. Хэрэглээний зээлийг хязгаарлах нь бизнесийн зээлийг дэмжих, ханшийг тогтворжуулах зорилготой богино хугацаандаа нийцтэй хэдий ч энэхүү арга хэрэгслийн гол зорилго нь биш гэж харж байна. Түүнчлэн, хэрэглээний зээл бизнесийн зээлтэй харьцуулахад илүү уян хатан, хурдан байдаг учраас ихээхэн өссөн. Үүнд хязгаар тавьснаар эдгээр нь бизнесийн зээл болж хувирах шаардлага гарна.



Зээлийн үзүүлэлт /2018 он 12 сар/



Банкуудын зээл өмнөх оноос 26.4% өссөн, үүнээс иргэдэд олгосон зээл **34.9%** өсч 8.9 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх ердөө **16.9%** өсч 7.9 их наяд төгрөгт хүрчээ.

Иргэдийн нийт зээлийн бүтэц



Иргэдэд шинээр олгосон зээлийн бүтэц



2017 оны 12-р сард иргэдийн зээлийн үлдэгдэлд цалин тэтгэвэрийн зээл 31%-ийг бүрдүүлж байсан бол энэ дүн их хэмжээгээр өсч 2018 оны 12-р сард 37%-д хүрсэн байна.

12-р сард иргэдэд шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 69.4 хувийг цалин тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын зээл бүрдүүлсэн байна.



“ТИНКБАНК 2019-МӨНГӨ, САНХҮҮГИЙН ОРЧИН” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ НЭЭЖ МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАЯРТСАЙХАНЫ ХЭЛСЭН ҮГ**

Улсын Их Хурал (УИХ)-ын Эдийн засгийн байнгын хороо болон Монголбанкнаас хамтран зохион байгуулж байгаа “ТинкБанк 2019-Мөнгө, санхүүгийн орчин” сэдэвт хэлэлцүүлэгт бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Монголбанк эдийн засгийн сэргэлт, түүний хүртээмжтэй байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулж байна. Сүүлийн 3 жилд Монголбанк өргөн хэмжээний шинэчлэл, реформуудыг хэрэгжүүлж, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргээ амжилттай биелүүлж байна. Тухайлбал, банк санхүүгийн системд хууль эрхзүйн шинэчлэлийг амжилттай хийж, Төв банкны хараат бус байдлыг баталгаажууллаа. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль зэрэг хуулиудыг шинэчлэн батлуулснаар Төв банкны сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь санхүүгийн салбарт болсон чухал үйл явдал байлаа. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, банкны салбарыг илүү эрүүл, чийрэг байлгах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монголбанк мөнгө, ханшийн бодлогоос гадна макро зохистой бодлого хэрэгжүүлдэг болж, бодлогын арга хэрэгслүүдээ өргөжүүлж, тэдгээрийг үр ашигтай ашиглаж байна. Төв банкны үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадлаа. 2018 он эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жил болж өнгөрлөө. Мөнгө, зээлийн зохистой өсөлтийг хангасанаар инфляци зорилтот түвшнээс бага буюу 7.3 хувьтай, харин эдийн засаг 6.9 хувиар өсч, сэргэлт эрчимжиж байна. Эдийн засагт гарсан нааштай, эерэг нөхцөл байдалд тулгуурлан зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэний үр дүнд банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 оны эцэст 16.9 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2.5 нэгж хувиар буурав. Зээлийн хүүний бууралтын нөлөөгөөр банкуудын бизнесийн зориулалттай, төгрөгөөр олгосон зээл өнгөрсөн онуудтай харьцуулахад өндөр хувиар өслөө. Энэ нь бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байр, үйлдвэрлэл өсөхөд чухал түлхэц болов.

Монголбанк гадаад валютын нөөцийн дотоод гол эх үүсвэр болох үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгө, ханшийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлснээр гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг

сүүлийн 2 жилд 3.5 дахин өсгөн 3.6 тэрбум ам.доллар (импортын 8 орчим сарын хэрэгцээг хангах түвшин)-т хүргэн нэмэгдүүлээ. Энэ нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт итгэлийг сэргээх, улсын эрсдэлийг бууруулж, зээлжих зэрэглэл нэмэгдэхэд нөлөөлсөн үндсэн хүчин зүйлсийн нэг байв. Ийнхүү макро эдийн засгийн тогтвортой байдал, сэргэлт хангагдаж, зээлжих зэрэглэл нэмэгдсэн нь Засгийн газар, Хөгжлийн банк, Монголын Ипотекийн Корпораци болон бусад хувийн секторын гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх хүү бага байх, валютын дотогшлох урсгал нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлэв. Гэхдээ ГВАН-ийн хүрсэн түвшинг том дүнтэй интервенци хийх замаар эргүүлээд үрэн таран хийх нь эдийн засгийн дунд хугацааны төлөвт эргээд маш ноцтой эрсдэлүүдийг бий болгоно. Ялангуяа, гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр валютын ханш сулрах зах зээлийн нөхцөл бүрдсэн, сөрөг үр дагавар нь харьцангуй удаан үргэлжлэхээр бол интервенциэр ханшийг хүчээр барих оролдлого нь ГВАН-ийг шавхах л үр дагаварт хүргэнэ. Харин богино хугацааны хэт огцом хэлбэлзлийг бууруулах, валютын ханш суурь нөхцөлтэй нийцтэй түвшинд байлгах чиглэлд Монголбанк валютын зах дээрх оролцоогоо үргэлжлүүлнэ. Иймд нэг талдаа эдийн засгийн дархлааг хангах, эмзэг байдлыг бууруулах, нөгөө талдаа ханшийн хэт өндөр хэлбэлзэлийг бий болгохгүй байх, энэ зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанкны бодлого чиглэж байна.

Монгол Улс Ази тивийн улсуудаас хамгийн түрүүн активын чанарын үнэлгээ /AQR/-г хийлгэсэн орон болов. Активын чанарын үнэлгээний болон холбогдох бусад арга хэмжээний үр дүнг үндэслэн Монголбанкнаас төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөнд активын чанарын үнэлгээний үр дүнг банкуудын тайланд тусгах, чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай буюу дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажлууд хийж байна. Эрүүл банкны салбартай байх нь эрүүл санхүүгийн салбар бий болгож, улмаар эдийн засгийн эрүүл суурь бүрдүүлдэг тул Монголбанкнаас 2019 онд банкны салбарт хийж буй ажлуудыг үргэлжлүүлнэ. Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах талаар эрчимтэй ажиллах. 2019 он Монголын банкны салбарыг хүчирхэг болгох жил байх болно.

Монгол Улсын Засгийн газар, ОУВС-ийн хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанк бүх талаар дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд тохирсон төв банкны дотоод цэвэр активын дээд хязгаар, гадаад цэвэр активын доод хязгаарын тоон зорилтууд болон урьдчилан авах хэмжээнүүдийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн хөтөлбөрийн үнэлгээг амжилттай хийлгэж ирлээ. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь манай эдийн засгийн хэтийн төлөвт стратегийн чухал ач холбогдолтой. Тэр дундаа, Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үргэлжлүүлэн хангахад ОУВС болон бусад доноруудын тусламж дэмжлэг цаашид ч онцгой шаардлагатай юм. Иймд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусгахын төлөө Монголбанк үргэлжлүүлэн зүтгэж ажиллах болно.

Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, эдийн засгийн хэтийн төлөв болон судалгааны ажлуудын үр дүнгээ олон нийтэд хүргэх зорилгоор жил бүр ‘ТинкБанк’ хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар шийдвэрлээд байна. Энэ жилийн хувьд ‘Тинкбанк 2019-Мөнгө, санхүүгийн орчин’ сэдвийн хүрээнд эдийн засгийн хэтийн төлөв, мөнгөний бодлого, валютын захын нөхцөл байдал, гадаадын банкны санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө зэрэг бодлогын асуудлуудыг хамарсан илтгэлүүд болон эдийн засгийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой судалгааны ажлын үр дүнгүүдийг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэхээр энэ арга хэмжээг зохион байгуулж байна. УИХ-ын удирдлагын зүгээс энэ жилийн хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж, хэлэлцүүлгийн нэр хүндийг өргөж, ач холбогдол өгч байгаад Монголбанкны зүгээс талархаж байна.

Энэхүү хэлэлцүүлэг нь эдийн засаг, санхүүгийн орчинд гарч буй өөрчлөлт, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд учирч буй сорилтууд, шийдвэрлэх арга замыг олох, нэгдсэн ойлголттой болоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Иймд Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид та бүхнийг эдийн засгийн тогтвортой байдалд тулгамдаж байгаа асуудал, сорилтууд болон шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БЭРХ ХААНЫ МӨНГӨН ЗООС 1257 - 1267 ОЧ

КРЫМ ХОТ

Жин: 2.1 гр

Голч: 2.3 см

1257 - 1267

Нүүр тал: Бэрх хааны тамгатай. Тамганы хоёр талаар "Крымд дэлдүүлэв" гэж бичсэн.

Ар тал: "Исламын эзэн хаан" гэсэн араб бичигтэй.





ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ СЭРГЭЭЖ, МӨНГӨ САНХҮҮГИЙН ОРЧНЫГ ТОГТВОРЖУУЛНА

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Монголбанк хамтран эдийн засгийн хэтийн төлөв, мөнгөний бодлого, валютын захын нөхцөл байдал, гадаадын банкны санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө зэрэг бодлогын асуудлуудыг хамарсан сэдвийн дор "Тинкбанк 2019-Мөнгө санхүүгийн орчин" хэлэлцүүлгийг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан юм. Энэ үеэр эдийн засагчдын танилцуулсан судалгааны үр дүн, дэвшүүлсэн асуудлуудыг төрийн бодлого боловсруулахад тусгах нь зайлшгүйг оролцогчид хэлж, эдийн засагт гарсан эерэг өөрчлөлтөд мөнгөний бодлогын нөлөө өндөр байсныг хэлэлцүүлгийн явцад дүгнэлээ.

Хэлэлцүүлгийг нээж УИХ-ын дарга Г.Занданшатар хэлсэн үгэндээ сүүлийн хоёр жилд эдийн засагт гарсан нааштай үзүүлэлтүүдийг юуны өмнө цохон тэмдэглэсэн юм. Тодруулбал, Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад

чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт сэргэж, өрийн дарамтаас гарч, эдийн засгийн байдал тогтворжиж, улмаар эдийн засгийн өсөлт 6.9 хувьд хүрснээр хамгийн өсөлттэй орнуудын тоонд зүй ёсоор ороод байна. Монгол Улс нийтдээ 6.5 их наяд төгрөгийн Засгийн газрын төсвийн өрийг төлж барагдуулав. Ингэснээр өрийн дарамт буурч, дефолт үүсэх эрсдэлээс ангижирч, өрийн тогтвортой байдал руу шилжих боломж бий боллоо. Инфляцийн түвшин 7.3 хувь, Улсын төсөв 10.9 тэрбум төгрөгийн ашигтай гараад байна. Энэ нь сүүлийн найман жил улсын төсөв ашигтай гарч байгаа анхны тохиолдол юм. Банкны системд Монголбанк 22 тонн алт худалдаж авсан нь мөн сүүлийн жилүүдэд байгаагүй өндөр амжилтыг үзүүлсэн нь валютын нөөцийг тогтворжуулах, нэмэгдүүлэх, ирээдүйд өрийн дарамтыг бууруулахад чиглэсэн ахиц амжилт байлаа.

Нөгөөтэйгүүр 2016 оноос хойш иргэдийн хадгаламж бараг 40 гаруй хувиар өссөн нь зөвхөн цөөн хүмүүсийх бус, нийт иргэдэд хүртээмжтэй өсөлт байж, аймаг, хөдөө орон нутагт мөнгөн хадгаламж нэмэгдсэн дүнг статистик тоо баримтаас харж болох юм. Сүүлийн гурван жилд ажилгүйдлийн түвшин тасралтгүй буурсаар 6.6 хувьд хүрсэн. Зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн жил гаруй хугацаанд нийт 3 орчим нэгж хувиар буурлаа. 2018 оны эцэст зээлийн жигнэсэн хүү 16.9 хувьд хүрсэн нь сүүлийн долоон жилийн хамгийн бага түвшин болж байна.

УИХ-ын дарга Г.Занданшатар хэлсэнүгэндээ мөн энэ онд баримтлах төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь бүхэлдээ санхүү, банк, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. Эдийн засагт бий болж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг бэхжүүлэх, цаашид эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг бодлого, арга хэмжээг хамарч байгаагаараа онцлогтой. Сүүлийн хоёр жилд банкны салбарын хууль, эрх зүйн өөрчлөлт шинэчлэл амжилттай хэрэгжлээ. Энэ оны хувьд банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг шат дараатай арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ гэсэн юм. Тэрээр тус хэлэлцүүлгийн зорилгыг тодорхойлохдоо, буруу мэдээлэл, улстөржилтөөс шалтгаалсан сөрөг нөлөө, зохисгүй хүлээлт буюу субъектив тал давамгайлсан байдлыг зохицуулах замаар

нийгэмд зохистой хүлээлтийг бий болгох, долларжих үзэгдлийг тогтворжуулах, бууруулах, төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд юу хийвэл зохистойг ярилцах, эрдэмтэн судлаачдын судалгаа, олон нийтийн санаа бодол, баримт нотолгоонд суурилахад оршихыг хэлсэн юм. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бичил санхүү, итгэлийн зээлийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсад ядуурлыг бууруулах чиглэлээр мөнгө санхүүгийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа тэргүүн туршлагаудыг нэвтрүүлэх, мөнгөний бодлогыг бодит эдийн засагт илүү наалдацтай болгоход чиглэсэн томоохон бодлогын шинжилгээ хийх, валютын дотоод захын журмыг өөрчилж шинэчлэх, валютын захын үйл ажиллагааг илүү нээлттэй, тогтвортой, хариуцлагатай болгохын төлөө ажиллахыг тэрээр үгийнхээ төгсгөлд хүссэн билээ.

Хэлэлцүүлэгт Монголбанкнаас мөнгөний бодлого, валютын захын нөхцөл байдал, хүүний тэнцвэрт байдлыг хэрхэн тодорхойлох, экспорт импортын эрэлт болон финтекийн хөгжил, эрх зүйн зохицуулалтын талаар илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Хэлэлцүүлгийн эхэнд “Эдийн засгийн төлөв, мөнгөний бодлого” илтгэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газрын дарга Б.Баярдаваа танилцуулсан юм. Түүний тавьсан илтгэлийн гол агуулга нь мөнгөний бодлого, эдийн засгийн сэргэлт, гол үзүүлэлтийг хамрав. Монголбанкнаас 2016 оны 8 дугаар сард бодлогын хүүг өсгөж, мөн оны 12 дугаар сараас эдийн засгийн

төлөв байдал, инфляцийн зорилтот түвшин, хэтийн төлөв, гадаад эдийн засгийн орчны төлөв гэх зэрэг холбогдох хүчин зүйлсийг харгалзан үзэж мөнгөний бодлогын хүүг шат дараалалтайгаар бууруулсан билээ. Үүний зэрэгцээ хэрэглээний зээл болон валютын ханшийн эрсдэлтэй зээлүүдэд арга хэмжээ авах зэргээр макро зохистой бодлогын арга хэмжээг 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь ханшийг тогтворжуулж, бизнесийн зээлийг идэвхжүүлэх үр нөлөөг үзүүлж эхэлжээ. Нэг ёсондоо, бодлогын хүү нь санхүүгийн зах зээлийн жишиг хүүг тогтоох, зээл, хадгаламжийн хүүг бууруулах, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилтыг агуулж байгаа бол макро зохистой бодлогын хүрээнд санхүүгийн нөөцийн хуваарилалтад нөлөөлөх, бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, өрхийн өрийн дарамтыг бууруулах зорилготой аж.

Инфляцийн хувьд, 2016 оны сүүлийн хоёр улирлыг дамжсан дефляци ямартай ч сэргэсэн бөгөөд энэ нь эдийн засаг агшилтаасаа өсөлтийн мөчлөг рүү орсонтой холбоотой байв. Эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор инфляци зорилтот түвшиндээ хүрсэн боловч анхаарвал зохих нийлүүлэлтийн шинж чанартай хүчин зүйлс байгааг тэрээр онцоллоо. Үүн дотор эрэлтийн шинжтэй дарамт сүүлийн хоёр жилийн туршид 3.7-4.5 хувь орчимд хэлбэлзэж, мах, хатуу түлш, нефтийн дотоодын болон дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл зэрэг хүчин зүйлс инфляцид гол хамааралтай байсан аж. Цаашид инфляцид эдийн засгийн сэргэлт, төсөв мөнгөний бодлогын арга хэмжээ, төгрөгийн ханшийн дамжих

нөлөө, дэлхийн зах зээлийн нефтийн үнэ, цалингийн өсөлт, төрийн зохицуулалттай үнэ, цаг агаар болон бусад нийлүүлэлтийн хүчин зүйлс нөлөөлнө гэдгийг илтгэлд дурдаж байв. Тэрээр анхаарах асуудлуудын талаар илтгэлийнхээ төгсгөлд онцлохдоо, гадаад сектор талдаа импортын орц, гадаад өр, хүүгийн төлбөр, ногдол ашиг, импортын үйлчилгээний төлбөр зэрэг нь өндөр байгаа. Тэгвэл бодит секторын тухайд, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, ингэснээр иргэдийн орлогыг үнийн дарамтгүйгээр өсгөх, үүний тулд эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтууд шаардлагатай гэлээ. Санхүүгийн салбарт банкуудын эрсдэл даах чадварыг хамгаалах, зээл олгох үйл явцыг тогтвортой болгох шаардлага бий. Энэ нь Төв банкны үндсэн зорилтын нэг үзүүлэлт бөгөөд эдийн засгийн цаашдын тогтвортой байдалд бодит нөлөө үзүүлэх юм байна.

Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин Монгол Улсын валютын зах зээлийн онцлог, өнгөрсөн 3 жилийн валютын зах зээлийн нөхцөл байдал, Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, цаашид хүлээгдэж буй сорилтуудын талаар “Валютын захын нөхцөл байдал, Төв банкны оролцоо” сэдэвт илтгэл танилцуулсан юм. Уг илтгэлд Монгол Улсын хувьд валютын ханшийг тодорхойлох суурь хүчин зүйл нь урсгал дансны алдагдал байсаар байгааг холбогдох тоон үзүүлэлтэд тулгуурлан дэлгэрэнгүй тайлбарлав. Сүүлийн 10 жилд

Монгол Улсын эдийн засаг урсгал дансны алдагдалтай явж иржээ. Худалдааны данс ашигтай байгаа боловч үйлчилгээний болон анхдагч орлогын дансны алдагдал өндөр, цаашид хэвээр үргэлжлэх төлөвтэй байгаа нь урсгал дансны алдагдалд гол нөлөө үзүүлж байгаа аж. Ингэснээр сүүлийн 15 жилийн хугацаанд төгрөг ам.долларын эсрэг ердөө гурван жил чангарч, үлдсэн 12 жилд нь суларч байжээ. Тодруулбал, дэлхийн зах зээл дээр манай улсын экспортын гол түүхий эд болох зэс, алтны үнэ өсөлттэй байсан 2006 онд 5 хувь, Оюутолгойн гэрээ байгуулсан 2010 онд 13 хувь, эдийн засгийг тогтворжуулахаар Монголбанк, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2017 онд 2.5 хувиар төгрөг ам.долларын эсрэг тус тус чангарч байжээ. Суларсан үзүүлэлтийг дундачлан тооцвол жилд 8 орчим хувь байсан гэлээ. 2018 онд төгрөг ам.долларын эсрэг 8.9 хувиар суларсан нь гадаад, дотоодын олон хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Валютын үнэ бол эрэлт, нийлүүлэлт, хүлээлтээс хамаарч хэлбэлздэг бөгөөд манай улсын хувьд валютын орлого цөөн тооны түүхий эдийн экспортоос шалтгаалдаг. Монгол Улсын нийт экспортын 90 орчим хувийг эрдэс баялгийн экспорт эзэлдэг төдийгүй цөөн тооны аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай байдаг онцлогтой. Тухайлбал, 2018 онд гадаадын 1.9 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсад хийгдсэний 1.5 орчим тэрбум ам.доллар нь Оюутолгойн бүтээн байгуулалттай холбоотой байх жишээтэй. Гэтэл валютын эрэлт

нь олон төрлийн оролцогчийн нөлөөтэй байдаг.

Мөн үеэр Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл “Эдийн засгийн төлөв, инфляцийн дүн шинжилгээ” сэдэвт илтгэл танилцуулсан юм. Тэрбээр 2011 оноос хойш хийгдсэн жижиг, дунд үйлдвэрийн түүвэр судалгааг нэгтгэн дүгнэсэн бөгөөд бизнес эрхлэгчид бизнесийн орчныг хэрхэн үнэлсэн талаарх дүнг танилцуулав. 2018 оны судалгаагаар 1922 бизнес эрхлэгчээс судалгаа авахад 45 хувь нь үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, 8 хувь нь тусгай зөвшөөрөл авахаар хөөцөлдөж байгаа гэсэн бол үлдсэн 47 хувь нь тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа гэжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын бизнесийн сектор нь дээрх хэмжээний албан болон албан бус бүтцээс бүрдэж байгааг хэлж байлаа. Иймд засаглал, институцийн реформыг 2019 онд багтаан хэрэгжүүлэх шаардлага байгааг илтгэгч тэмдэглээд, төр болон зах зээлийн харилцаанд чанарын эргэлт хийх зайлшгүй хэрэгцээ бийг цохон тэмдэглэв. Дээр дурдагдсан үзүүлэлттэй нөхцөлд энэхүү реформыг хийх үндсэн үзэл санаа нь бизнесийн үйл ажиллагааг хэрхэн албажуулах талаар байх ёстой гэлээ. Зөвхөн албан секторт байгаа компаниудтай ажиллах бус, нөгөө талд байгаа зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг албажуулах эрх зүй, эдийн засгийн үйл явцыг реформын гол үзэл санаа болгох нь зүйтэй гэдэг байр суурийг хэлж байв. Түүнчлэн эдийн

засгийн өсөлтийг хүртээмжтэй, тогтвортой байлгахад тоон болон чанарын анализ хийх нь чухал ач холбогдолтой гэв. 2016-2018 оныг улирлуудаар авч үзэхэд өрхийн эцсийн хэрэглээний зардал буурч, сөрөг утгатай байжээ. 2016 онд материалаг эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт эерэг утгатай ч буурах хандлагатай, 2017 онд аль аль нь эерэг утгатай өсөж байсан ч материалаг эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт давамгайлсан байна. 2018 онд харин өрхийн эцсийн хэрэглээний зардал давамгайлсан хандлагатай байжээ. Энэ нь хөрөнгө оруулалтын өөрчлөлтөд үнийн өсөлтийн нөлөө их өндөр байсны илэрхийлэл гэлээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт биет байдлаар нэмэгдэхээс гадна үнийн өсөлтийн нөлөө их байсан байна. Өмнөх жилүүдээс харахад Монгол Улс эдийн засгийн хэлбэлзэлтэй үед хэрэгжүүлэх тодорхой бодлогогүй байдагтай энэ нь холбоотой хэмээн тэрээр шүүмжилж байв. Тиймээс цаашид, нэн тэргүүнд валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газрын оролцоо, үүрэгтэй байх ёстой бөгөөд хариуцагч нь тодорхой, бодлого болон хэрэгжилтийн түвшинд бодитой ажил хийх шаардлагатай. Эдгээр илтгэл, хэлэлцүүлгийн үр дүнгээр Улсын Их Хурал, тэр дундаа Эдийн засгийн байнгын хороо эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй, тогтвортой болгох чиглэлээр Засгийн газарт хандсан шийдвэр гаргах нь ач холбогдолтой гэсэн юм.

Глобал эдийн засгийн хүрээлэнгийн захирал Р.Амаржаргал “Гадаадын банкны санхүүгийн зах

зээлд үзүүлэх нөлөө, нэвтрүүлэхэд тохиолдох эрсдэлийг бууруулах арга зам” сэдэвт илтгэл танилцуулсан билээ. Юуны өмнө тэрээр манай улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа чамлалттай байдаг учраас нэн тэргүүнд үүнийг анхаарах, шаардлагатай мэдээллийн иж бүрэн датаг бүрдүүлэх нь чухал гэлээ. Банкны салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаарх тодорхойлолтыг гаргаж, ойлголтоо нэгтгэх шаардлага бий. Тодруулбал, банкны систем дэх нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 44.6 хувь нь гадны хөрөнгө, системийн нөлөө бүхий банкууд дахь гадны хөрөнгө оруулалт нь 43.6 хувь байгаа. Энэ дунд гадаадын төрийн өмчийн оролцоотой банкны асуудлыг нарийвчлан үзэх шаардлага бий гэдгийг дээрх судалгааны дүгнэлтэд дурдсан байна. Глобал эдийн засгийн хүрээлэн “Гадаадын банкны санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө, нэвтрүүлэхэд тохиолдох эрсдэлийг бууруулах арга зам” судалгааныхаа хүрээнд дотоодын банкны чадавх сулрах эсэх, хэрэглэгчээ сорчлох эсэх гээд 16-24 шалгуураар эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. Дээрх үнэлгээг хийснээр өнөөдрийн нөхцөлд боломж нь эрсдэлээсээ бага юм байна гэдэг дүгнэлт гаргажээ. Тодруулбал, өнөөдрийн нөхцөлд гадаадын банк санхүүгийн байгууллага манай улсад орж ирснээр боломжийг үүсгэхээсээ илүү эрсдэлтэй гэж үзжээ. Үүнд үндэслэн гадны банкуудын манайд нэвтэрч буй хэлбэрүүдэд түлхүү анхаарах, тодорхой зохицуулалт хийх хэрэгтэй гэв. Гадаадын банк аливаа улс оронд үйл ажиллагаа явуулах асуудлыг онолын түвшинд

эергээр тайлбарладаг хэдий ч Монгол Улсын онцлогийг харгалзах нь нэн чухал гэсэн юм. Тиймээс гадны туршлага гэдгээр тодорхойгүй байдлаар мэдээлэл түгээж, түүнийг нэвтрүүлэх, эсвэл шийдвэр гаргалтад жишээ болгон ашиглах нь нэн зохимжгүй. Судалгааг хийхдээ, тодорхой аргачлалаар Монгол Улсын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтийг ойрмогхон тооцоолж үзсэн бөгөөд хэвийндээ 200-300 байх ёстой тоон үзүүлэлт ердөө 59 хувьтай гарсан нь маш хангалтгүй хэмээж байв. Нөгөөтэйгүүр манай улсын геополитик хязгаартай бөгөөд үүнийг харгалзах ёстой гэв. Санхүүгийн зах зээл нь хөгжсөн, эдийн засгийн өндөр хөгжилтэй оронд бол гадны банк үйл ажиллагаа явуулахад түүний нөлөөллийн талаар онцлох шаардлагагүй байдаг бол дөнгөж хөл дээрээ зогсох гэж байгаа улс орны хувьд нэн эрсдэлтэй нөлөө үзүүлэх юм байна гэлээ. Нэн тэргүүнд дотоодын санхүүгийн зах зээлийг бойжуулах, тогтвортой өсгөж тэлэх үйл ажиллагаа, арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг дүгнэлтийг хэллээ. Үүний тулд төр нь эдийн засгийн активыг өргөтгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулах шаардлагатай аж. Активыг нээлттэй болгох, бизнесийнхэнд орон зайг нь тэлж өгөх, хүртээмжтэйгээр үйл ажиллагаа явуулах активын орон зайг нь тэлэх чиглэлээр Засгийн газар онцгой үүрэгтэйгээр ажиллах шаардлагыг тэрбээр илтгэлийнхээ төгсгөлд хэллээ.

Ийнхүү дээрх дөрвөн илтгэлийг танилцуулсны дараа хуралд оролцогчид илтгэлүүдийн хүрээнд сонирхсон асуултдаа хариулт авч,

санал солилцон, байр сууриа илэрхийлсэн юм. Монгол Улс эдийн засгийн хувьд өөрийгөө тэтгэх арга замыг тодорхойлох нэн чухал шаардлага бийг талууд анхаарах нь зүйтэй гэдэг байр суурийг академич Т.Дорж илэрхийлж байв. Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол зээлийн хүүг дорвитой бууруулах, итгэлийн банк байгуулах санаачилгад хамтран ажиллах гэсэн хоёр асуудалд Монголбанкны зүгээс анхаарал хандуулах хүсэлтээ хэлж байв. Хөрөнгийн үйлчилгээний активыг боловсронгуй болгох замаар Монгол Улс 2020 онд актив, пассивын дансыг байгуулах шаардлагын талаар Үндэсний статистикийн хорооны Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга А.Дэмбэрэл хэлж,

зарим зүйлийг холбогдох албан тушаалтнуудаас тодруулж байлаа.

Үргэлжлүүлэн Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир “Тэнцвэрт хүүний түвшинг үнэлэх нь”, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн захирал Л.Даваажаргал “Бизнесийн мөчлөгийг тодорхойлох нь”, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын ахлах эдийн засагч Б.Дуламзаяа “Монгол Улсын экспорт, импортын эрэлт: орлого болон үнээс хамаарах мэдрэмж”, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч С.Билгүүнзул “Финтекийн хөгжил, эрх зүйн зохицуулалт: олон улсын туршлага”сэдэвт илтгэлийг тус тус танилцуулснаар хэлэлцүүлэг өндөрлөлөө. Хэлэлцүүлгийн

төгсгөлд Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэхдээ, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийн хэрэгжилтэд анхаарах, худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага бий гэдгийг онцолж байв. Мөн тэрбээр төрийн байгууллагууд судалгааны институцийг бэхжүүлж, үйл ажиллагааг эрчимжүүлэн бодлого боловсруулах үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглаж байх нь чухал ач холбогдолтойг чухалчилж байлаа. Хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд Байнгын хорооны тогтоол боловсруулан, батлах юм.



ТАЙЛАН БҮРТГЭЛИЙН ГАЗАР



1

Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, хэрэгжүүлж ажиллана.



2

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхойлсны дагуу гадаад валютын улсын нөөц, Монголбанкны дотоод төлбөр тооцоо, Эрдэнэсийн сан, банк хоорондын төлбөр тооцоотой холбоотой аливаа ажил гүйлгээг анхан шатны баримтанд үндэслэн бүртгэнэ.



3

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэнэ.



4

Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, шаардлагатай тайлан мэдээг бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангана.



5

Банкууд, Засгийн газартай байгуулсан гэрээний үндсэн дээр банкууд Сангийн яам болон бусад Засгийн газрын холбогдох байгууллагуудын төлбөр тооцоог гүйцэтгэнэ.





ТӨВ БАНК УДААН ХУГАЦААНД АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАХ НЬ ҮНДСЭН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЖ ЧАДАХГҮЙД ХҮРЭХ ЭРСДЭЛТЭЙ

Төв банкны алдагдлын талаар Монголбанкны Тайлан бүртгэлийн газрын захирал Ц.Гарьдтай ярилцав.

Танай газар өдөр тутамд ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ?

Манай газар нь товчоор хэлбэл, Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу эрхэлдэг. Өдөр тутамдаа бол гадаад валютын улсын нөөц, Эрдэнэсийн сан, алт, үнэт метал, мөнгөн тэмдэгтийн бэлтгэл сантай холбоотой гүйлгээ, Монголбанкны дотоод төлбөр тооцоог хийж гүйцэтгэхээс гадна Сангийн яам, арилжааны банкуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр Засгийн газар болон банк хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг.

Тэгэхээр мэргэжлийн хувьд нягтлан бодогчид гол төлөв ажилладаг байх нь. Хэр өндөр шалгуурыг давж байж танай газарт ажиллах эрхтэй болох вэ?

Тийм шүү, мэргэжлийн нягтлан бодогчид голдуу ажилладаг. Манай газарт ажиллах хүн нягтлан бодогчоос гадна эдийн засагч, санхүүгийн шинжээч зэрэг мэргэжилтэй байдаг. Харин англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн, мэргэшсэн нягтлан бодогч байх гэсэн шалгуурыг хангах ёстой.

Монголбанк сүүлийн гурван жилийн дотор 3.0 их наяд төгрөгийн алдагдлаа бууруулсан гэж мэдээлж байсан. Алдагдлаа яаж бууруулсан бэ?

2017 онд 176.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, энэ хэмжээгээр хуримтлагдсан алдагдлыг бууруулсан. 2018 оны эцсийн байдлаар мөн тодорхой хэмжээний ашигтай гарсан. Одоогоор санхүүгийн тайлангаа олон улсын нэр хүнд бүхий хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ажил хийгдэж байна. 2012-2016 онд хуримтлагдсан алдагдал 3,0 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь богино хугацаанд нөхөж баршгүй өндөр алдагдал хэдий ч Монголбанк энэхүү алдагдлыг бууруулах чиглэлд анхаарч, 2017 онд ашигтай ажилласны зэрэгцээ 2018 онд Эрдэнэсийн сан болон үл хөдлөх хөрөнгөд хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлгээ хийлгэж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тайлан тэнцэлд тусгасны үр дүнд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг 1.2 их наяд төгрөгөөр бууруулаад байна. Мөн 2018 онд хэрэгжүүлсэн "Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа" аяны үр дүнд худалдан авсан алтны хэмжээ 22 тоннд хүрч, гадаад валютын улсын нөөцийн хэмжээ 3.5 тэрбум ам.доллар болж өссөн нь цаашид гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэгсэл гаргахгүй байх боломжийг бүрдүүллээ.

Монголбанкны ашиг алдагдал гэж юу болохыг энэ дашрамд манай уншигчдад тайлбарлаж өгөөч. Энэ нь Монголбанкны үйл ажиллагаанд чухам яаж нөлөөлдөг юм бол?

Ер нь Монголбанкны ашиг, алдагдал нь үйл ажиллагааны болон хөрөнгийн ашиг алдагдлаас бүрддэг л дээ. Монголбанк нь төсвийн шинжтэй үйл ажиллагаанд оролцохгүй үед үйл ажиллагааны орлогын дийлэнх хувийг гадаад валютын улсын нөөцийн өгөөж, өөрөөр хэлбэл, гадаадын банкинд байршуулсан хадгаламжийн хүүгийн орлого, гадаадын Засгийн газар болон нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудын гаргасан үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлдэг. Харин зардлын дийлэнх хувийг Төв банкны үнэт цаасны хүүгийн зардал эзэлдэг. Түүнээс гадна арилжааны банк, санхүүгийн байгууллагад Монголбанкнаас олгосон зээлийн хүүгээс тодорхой хэмжээний орлого олдог. Тухайлбал, Монголбанкны 2017 оны санхүүгийн тайлангаас харахад хүүгийн орлогын 32 хувийг санхүүгийн хөрөнгө оруулалтаас, 27 хувийг дотоодын байгууллагуудад гаргасан үнэт цааснаас, 14 хувийг банкуудад олгосон зээлээс, 13 хувийг Засгийн газрын үнэт цааснаас тус тус олсон байгаа юм. Хүүгийн зардлын 50 хувийг гадаад өр төлбөрийн хүү буюу Хятадын ардын банкнаас авсан своп зээлийн хүү, 36 хувийг Төв банкны үнэт цаасны хүүгийн зардал, 13 хувийг заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан банкуудад олгосон урамшууллын зардал эзэлж байна. Хөрөнгийн ашиг, алдагдал нь гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэлийн зөрүүгээс үүсдэг. Тухайлбал, гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгө, өр төлбөрийн харьцаа зөрүүтэй байх үед төгрөгийн ханш чангарах, эсвэл сулрахад хамаарч ашиг, алдагдал үүсч байдаг. Жишээлбэл, Монголбанкны тэнцлийн пассив буюу өр төлбөр талд Хятадын ардын банкнаас авсан своп зээл бүртгэлтэй байдаг. Төгрөгийн юаньтай харьцах ханш сулрахад ханшийн тэгшитгэлийн алдагдал нэмэгдэж, ханш чангарахад алдагдал буурна гэсэн үг.

Төв банкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах явдал байдаг. Удаан хугацаанд алдагдалтай ажиллах нь төв банкны бие даасан, хараат бус байдал болон мөнгөний бодлогын үр нөлөөнд сөргөөр нөлөөлж, өөрийн гол үүргийн нэг болох инфляцийг нам түвшинд барих чадвараа алддаг гэж үздэг. Ингэснээр төв банкны үндсэн зорилт болох үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэлтэй.

Ер нь Монголбанк алдагдалтай ажиллаж ирсэн тохиолдол хэзээнээс эхэлсэн бэ? Үүний шалтгаан нь юу байв?

Үндсэндээ 2012 оноос алдагдалтай ажиллаж эхэлсэн. Энэ нь Монголбанк уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ унаж, гадаад валютын орох урсгал татарсан үед Монголбанкнаас төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, өндөр зардалтай төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан нь алдагдлын гол шалтгаан болсон. Төгрөгийн нийлүүлэлт нэмэгдсэнээс гадаад валютын нөөцийн хүрэлцээ алдагдсан. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан байдлыг хангаж чадаагүй. Тухайлбал, гадаад валютын зах зээлд хэт их оролцож, тогтмол өндөр дүнгээр интервенц хийснээр ханшийг тогтвортой барихыг зорьсон ч төгрөгийн ханш суларч, гадаад валютын нөөц шавхагдаж, гадаад валютаар илэрхийлэгдэх өр төлбөр нь хөрөнгийнхөө хэмжээнээс давсан үед ингэж төгрөгийн ханш суларсан нь төв банк ханшаас алдагдал хүлээх суурь шалтгаан болсон.

Түүнчлэн урсгал дансны алдагдлыг гадаад зээл, бондоор санхүүжүүлж, дотоодын арилжааны банкуудтай зах зээлийн хүүгийн түвшнөөс хэт доогуур ханшаар урт хугацаат своп хэлцэл байгуулсан нь алдагдлын бас нэг шалтгаан болжээ. Мөн арилжааны банкууд болон аж ахуйн нэгжүүдэд зах зээлийн хүүгээс хэт доогуур хүүтэй зээл олгосон нь зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг бий болгосон. Түүнээс гадна Монголбанк аж ахуйн нэгж, арилжааны банкуудын ханшийн эрсдэлийг өөртөө хүлээх хэлцэл байгуулж, хүүний татаас хэлбэрийн зах зээлийн бус аргыг ихээр хэрэглэсэн нь Монголбанкны өөрийн хөрөнгийг сөрөг утгатай болоход нөлөөлсөн. Дээр дурдсан уламжлалт бус бодлогоос үүдэн Монголбанкны 2016 оны алдагдлын 22 хувийг санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал, 16 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал, 15 хувийг зах зээлийн хүүгээс доогуур хүүгээр олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал, 15 хувийг Хятадын ардын банкнаас авсан зээлийн хүүгийн зардал эзэлсэн.

Алдагдалгүй ажиллах боломж бий юу?

Олон улсын туршлагаас харахад Бразил, Чех, Унгар, Солонгос Тайланд зэрэг улсын төв банкууд ямар нэг хэмжээгээр алдагдалтай ажиллаж байсан.



Монголбанкны Тайлан, бүртгэлийн газрын хамт олон.

Алдагдлыг арилгасан нийтлэг арга хэмжээнүүд нь тухайн улсын засгийн газар үнэт цаас гаргах замаар алдагдлыг санхүүжүүлэх, эсвэл төв банк нь төсвийн шинжтэй үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээ зогсоож, өөрөө алдагдлаа хариуцан арилгасан байдаг. Манай улсын тухайд бол Төв банкны тухай хуульд “Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэж заасан байдаг. ОУВС-ийн зүгээс аливаа төв банк алдагдалтай ажилласан тохиолдолд алдагдлыг улсын төсвөөс бэлэн мөнгө олгох эсвэл Засгийн газрын бонд гаргах замаар алдагдлыг санхүүжүүлэхийг зөвлөдөг. Гэвч төсвийн алдагдал өндөр, Засгийн газрын өрийн тогтвортой байдал эрсдэлтэй байгаа энэ үед Засгийн газар өндөр дүнгээр үнэт цаас гаргах боломж хомс байгаа тул Монголбанкны алдагдлыг энэ аргаар шийдвэрлэх боломжгүй байгаа юм. Тиймээс Монголбанк хуримтлагдсан алдагдлыг бууруулах чиглэлээр төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулах, своп, форвард хэлцлүүдийг алдагдал хүлээх хэлбэрээр байгуулдаг байдлыг зогсооход анхаарч ажилласны үр дүнд алдагдалгүй ажиллах боломж үүсч, 2017 оноос эхлэн Монголбанк ашигтай ажиллаж эхлээд байгаа.

Үлдсэн алдагдлаа ямар хугацаанд нөхөх төлөвлөгөө байгаа вэ?

Дээр дурдсанчлан Монголбанкны хуримтлагдсан алдагдал нь богино хугацаанд нөхөгдөх боломжгүй хэмжээнд нэгэнт хүрсэн. Тиймээс Монголбанк нь мөнгөний бодлогоос гадуур үүрэг хүлээхгүй буюу төв банкны чиг үүрэгт тусаагүй, төсвийн шинжтэй бодлогын үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхгүй байх, зах зээлийн ханшаас хэт зөрүүтэй өртгөөр үүсмэл хэрэгсэл байгуулахгүй байх, хүүний татаасын зардал гаргахгүй байх, Засгийн газрын бондыг нээлттэй захын үйл ажиллагаанд ашиглах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, үүнд Монголбанкны гадаад өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах, алт тушаалтыг нэмэгдүүлэх, валютын захын оролцоог бууруулж, зах зээлийн зарчмаар ажиллах, банк хоорондын захын хөгжлийг дэмжих замаар Монголбанкны хуримтлагдсан алдагдлын сөрөг нөлөөг тогтвортой бууруулах боломжтой. Гэхдээ Монголбанкны ашиг, алдагдалд тухайн үеийн гадаад, дотоодын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан түүний явуулах мөнгөний бодлого ихээхэн нөлөөтэй тул Монголбанкны хуримтлагдсан алдагдлыг нөхөх тодорхой хугацааг товлон нь учир дутагдалтай юм.

Ярилцсанд баярлалаа.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ГЕНЕРАЛ СЭЛЭМ

Он: 1945

Жин: 1556 гр, 97 X 3.8 см

Ган төмрийг давтаж матигар хэлбэр оруулан дээр нь "МАХЦ-ийн генерал" хэмээх үгийг алтаар шарж хийсэн сэлэм. Бариулыг алтаар тоноглож хоёр талд нь бадмаараг эрдэнээр хийсэн таван хошуу шигтгэж. Бариулын хоёр талын угт 1940 оны төрийн сүлдийг байрлуулан сэлэмний балтыг (гар хамгаалагч) тойруулан бадмаараг чулуу шигтгэн чимэглэжээ.

Сэлэмний хуйг нимгэн гангаар үйлдэж, зүүсгэл тээг, төгсгөл хэсгийг түмэн наст болон хатан сүйх, үүлэн хээгээр чимэглэн алтаар шарж, хээ бүрийн дээр үнэт эрдэнийн чулууг шигтгэсэн байна.





МИХЕЛЬМАН, ДАНИИЛ ДАВЫДОВИЧ
1888 онд Хаант Орос (одоогийн Польш)-ын Варшав хотноо төрсөн. 1918 оноос Улс ардын аж ахуйн Дээд Зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1921 оноос Улсын банкны Москва конторын захирал, 1925-1927 онд Худалдаа аж үйлдвэрийн банкны Ерөнхий хорооны даргаар ажилласан. 1937 онд ЗХУ-ын Даатгалын Ерөнхий газрын даргаар ажиллаж байгаад улс төрийн хилс хэргээр баривчлагдан 1938.1.8-нд цаазлагдсан.

МОНГОЛ ДОЛЛАР
1921 онд доллар хэмээх мөнгөн тэмдэгтийг ЗХУ-д Москва хотын Госзнак хэвлэлийн үйлдвэрт хэвлэжээ. Данзангийн доллар гэж нэршсэн цаасан дэвсгэрийг уламжлалт хээ угалзаар чимэглэхдээ тасралтгүй мөнхөд үргэлжлэхийн бэлгэдэл хас, үргэлжид түгэн дэлгэрэхийн бэлгэдэл таван нүдэн хээг дүрсэлжээ.

ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ

ДОЛЛАРААС ТӨГРӨГТЭЙ БОЛСОН ТҮҮХ

Үндэсний мөнгө зээлийг тогтолцоог бүрдүүлсэн үйл явцыг ажиглахад, улс орныхоо зах зээл дэх мөнгөний эргэлтийг зохицуулах хөшүүргийг гартаа авах, үндэсний мөнгөн тэмдэгтээ гүйлгээнд оруулж эргэлтээс гадаадын валютыг шахан зайлуулах, санхүү, зээл тооцооны бүртгэлийг үндэсний нэгдсэн журам, загвар тогтоон хэрэгжүүлэх, улсын төсвийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний валют төгрөгөө, гадаад валютын довтолгоо интервенцээс хамгаалах гэсэн үндсэн чиглэлтэй байв.

ДАНЗАНГИЙН ДОЛЛАР

Ардын Засгийн газраас аль болох түргэн үндэсний мөнгөн тэмдэгтээ гүйлгээнд оруулж эдийн засгийн амьдралыг зохицуулахыг зорьж байв. Улмаар ЗОУ-ын талтай Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт гаргах асуудлаар хэлэлцэж 1921 оны 11 дүгээр сарын 24-нд “Монгол Улсын мөнгөн тэмдэгт хэвлүүлэх тухай гэрээ”-нд байгуулжээ. Мөнгөн дэвсгэрийн хэлбэр хэмжээ, өнгө зураг, мөнгөн тэмдэгт цаасыг үйлдэх дэвсгэр, цаасны яс чанарыг хоёр хувь үйлдэж хэвлүүлэн үзэж батлаад, баталсан маяг хэлбэрийг хэвлэлийн үйлдвэрт баримтлан тушаах, нийт зургаан төрлийн дэвсгэрийг хоёр хувааж, дөрвөн сарын дотор хэвлэх, эхний ээлжинд 1, 3,

10-тын дэвсгэрийн эх загварыг хүлээн авснаас хойш гурван сарын дотор хэвлэн гаргахаар тохиролцжээ. Тэмдэгт цаасны хэв загварыг марзан хэмээх Шарав урласан бөгөөд бат оршихын бэлгэдэл хас тэмдэг, махбодыг дүрсэлжээ. Гэрээний дагуу 50 мөнгөний тэмдэгт цаас 1 сая, нэг төгрөгийн тэмдэгт цаас 1 сая 50 мянга, гурван төгрөгийн дэвсгэрт 250 мянган, таван төгрөгийн дэвсгэрт 100 мянган, арван төгрөгийн дэвсгэрт 40 мянга, 25 төгрөгийн тэмдэгт цаас 12 мянган хуудас буюу нийт 2 сая 452 мянган ширхгийг Зөвлөлтөд хэвлүүлжээ. Гэвч энэхүү мөнгөн тэмдэгтийг Сангийн яамны тэргүүн сайд С.Данзангийн нэрээр “Данзангийн доллар” гэх болжээ. Үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд





оруулахад зайлшгүй байх гол нөхцөл, үндэсний банк, хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоо, эдийн засгийн бусад үйлчилгээ хараахан үүсч бүрэлдээгүй байснаас дээрх мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргаагүй юм. Монгол, Зөвлөлтийн Худалдаа аж үйлдвэрийн банк байгуулсны дараа үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулахаар завдсан боловч баталж үйлдүүлсэн тэмдэгт цаасны дотор аравт гуравтыг солилцуулан буруугаар үйлдсэн зэрэг техникийн зэрэг зарим шалтгааны улмаас энэ ажил хойшлогдсон байна. Энэ завсар С.Данзан хувьсгалт засаг төрд тэрсэлсэн хэргээр хэлмэгдсэн тул түүний нэрээр үйлдсэн мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргалгүй устгасан гэдэг.

ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ

1925 онд хуралдсан БНМАУ-ын II Их хурлаас “Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах тухай” тогтоол гаргажээ. Тогтоолд “тус улсын мөнгөн гүйлгээг сайжруулах ба өөрсдийн мөнгөн тэмдэг ба зоосыг гаргах тухай эл хэргийг үүсгэн явуулах нь нэн чухал бөгөөд цаг үе нь болсны дээр улс төрийн ба эдийн засгийн явдалд үлэмж тустай болох тул олон ардын ашиг тус, улсын санхүүгийн бодол, аж ахуйн ба худалдааны явдалд нийлүүлэн гүйцэтгүүлвэл зохино” гэж заасан ёсоор мөн оны 12 дугаар сарын 9-нд ЗХУ-д үйлдвэрлэсэн зоос болон цаасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргажээ. Төгрөг нь 88 мексик центтэй тэнцэж байхаар мөнгөний ханш тогтоожээ. 1928 оны эхэн хүртэл мексик доллар төлбөрийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэсэн байсан бөгөөд аажмаар

төгрөгийн үүрэг өсөн нэмэгдсээр 1927 оноос эхлэн байгууллага, аж ахуйн балансыг төгрөгөөр гаргах болсон байна.

Үндэсний мөнгө зээлийн тогтолцоог бүрдүүлэхэд үндэсний мөнгөн тэмдэгт гүйлгээнд оруулахын хамт түүний ханшийг тогтворжуулах, санхүү зээл, төлбөрийн бүх тооцоог төгрөгийн нэгжид шилжүүлэн тооцож жигдрүүлэх шаардлагатай байв. Учир нь улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос мексик доллараар хийж байсан тул мексик доллар, төгрөгийн ханшийн ялгаа зэрэг хүчин зүйлийн нөлөөллийг арилгах явдал чухалчлагджээ.

1927 онд хуралдсан БНМАУ-ын IV Их хурлаас “Улсын эдийн засгийн явдлыг хөгжүүлэн бататгах хэрэгт чухал холбогдох мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах хэргийг улам чанартай болгон явуулж, нэгэнтээгүүр тус улсын цаасан төгрөгийг алтан баталгаатай болгож, үнэ ханшийг тогтвортой болгох ба бас ч гадаадын мөнгөний зүйлийг тус хязгаарын дотор зарцуулахгүй болгох зэрэг явдлыг эрхбиш цаг зүйд нийлүүлэн явуулж, улсын ба ард олны аж ахуйн явдалд алдагдал хохиролгүй болгохыг чухалчлан оролдож гүйцэтгэвэл зохино” гэсэн шийдвэрийн дагуу Монголбанкнд хуримтлагдсан улсын алт болон валютын фондод түшиглэн 1928 оны дөрөвдүгээр сарын 15-наас төгрөгийг алтан баталгаанд оруулжээ. Ингэснээр БНМАУ-ын үндэсний валют “төгрөг” бат найдвартай валют болох үндэс тавигдаж 1928 оны наймдугаар сарын 1-н гэхэд төгрөг нь албан ёсны алтан баталгаанд орж 51.8 америк центтэй тэнцэх болжээ.

НЭГ ЗУУН ТӨГРӨГ

Цаасан дэвсгэрт дээр
1. Энэхүү банкны тэмдэгт цаасыг Монголын Худалдаа аж үйлдвэрийн банкнаас уул тогтоосны ёсоор мөнгөн төгрөгөөр солимой.
2. Банкны тэмдэгт цаасыг аливаа зүйлд өгч авалцваас зохимой.
3. Банкны тэмдэгт цаасыг дуурайлган хуурамчаар үйлдвээс хууль ёсоор цээрлүүлэн шийтгэмүй гэж бичжээ.

МОНГОЛ ТӨГРӨГ

БНМАУ-д 1925 оноос хойш долоон удаа буюу 1937, 1945, 1959, 1970, 1977, 1980, 1981 онд гүйлгээний зоос гаргасан бөгөөд тэдгээрийг ЗХУ, БНХАУ, БНАГУ-д үйлдвэрлэж байсан бол 1970 оноос дотооддоо үйлдвэрлэх болжээ. Харин цаасан мөнгөн тэмдэгтийг 1939, 1941, 1955, 1966, 1981 онд хэвлэж гүйлгээнд гаргажээ. Улсын Үндсэн хуулийг шинээр батлан мөрдсөн, албан ёсны бичиг өөрчлөгдсөнтэй уялдан мөнгөн тэмдэгт дээрх сүлд бэлгэдэл, үг үсгийг өөрчилж байсан юм.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.02.27)

Монголбанкнаас сар тутам зохион байгуулдаг хэвлэлийн бага хурал хоёрдугаар сарын 27-ны өдөр болж, банк, санхүүгийн салбарын статистик мэдээллүүдийг хүргэлээ. Мөн энэ үеэр сэтгүүлчдийн асуултад хариулав.

Блүүмбэрг ТВ:

Макро зохистой бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж эхлээд, эхний нэг сар өнгөрлөө. Нэг сарын хугацаанд ямар үр дүн харагдаж байгаа вэ, хэрэглээний зээл буурсан болов уу?

Мөнгөний бодлогын газрын Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал **Н.УРГАМАЛСУВД:**

Макро зохистой бодлогын арга хэмжээний хүрээнд авч үзсэн гурван арга хэмжээ 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тэгэхээр үүний үр нөлөөг ярихад эрт гэж бодож байна. Нэгдүгээр сарын байдлаар хэрэглээний зээлийн өсөлт өмнөх оны мөн үеэс 36 хувиар өссөн байгаа. Энэ мааны оны өмнө нь 57%-тай байсан бол он гарснаас хойш өсөлт нь аажмаар саарч байна. Хэрэглээний зээлийн хязгаарлалт хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2018 оны 11, 12 дугаар сард иргэд их хэмжээгээр хэрэглээний зээл авсан. Он гараад удаагүй, дөнгөж хоёр сар өнгөрч байна. Тийм учраас цаашид нэлээн хэдэн сар ажигласны үндсэн дээр хэрэглээний зээл ямар түвшинд хүрэх вэ гэдгийг дүгнэж хэлэх боломжтой юм. Одоо хэлэхэд харьцангуй эрт байна.

Блүүмбэрг ТВ:

ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн

хүрээнд 2018 онд хийгдэх байсан санхүүжилтүүд 400 орчим сая доллараар тасалдсан. Энэ онд дээрх дутагдсан санхүүжилтүүд орж ирэх үү, энэ онд хөтөлбөрийн санхүүжилтийн хүлээлт ямар байгаа вэ?

МБГ-ын МБТХ-ийн захирал **Н.УРГАМАЛСУВД:**

2018 оны хувьд орж ирэхээр төлөвлөгдөж санхүүжилтүүд хойшлогдсон байгаа. Одоогийн байдлаар тэдгээр хойшлогдсон санхүүжилтүүд 2019-2020 онуудад орж ирнэ гэсэн байдлаар ОУВС-ийн ажлын хэсэгтэй тохиролцоонд хүрсэн. 2019 онд орж ирэхээр төлөвлөгдсөн донор болон ОУВС-ийн зээлийн мөнгөн урсгалууд бүрэн орж ирнэ гэсэн төлөвлөгөөтэй байна.

News.mn:

Монгол Улсыг саарал жагсаалтад оруулах, эсэх асуудлаар эцсийн шийдвэр 2019 оны эхэнд гарна гэж байсан. Энэ асуудал хэрхэн шийдэгдэж байгаа вэ?

Санхүүгийн мэдээллийн албаны дарга **Х.БАТЧУЛУУН:**

Монгол Улсын мөнгө угаах тогтолцоог олон улсын энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд 2014-2018 оны хооронд үнэлсэн. Үнэлгээний дагуу Монгол Улсын холбогдох байгууллагууд ажлын төлөвлөгөө боловсруулаад 2017, 2018 онуудад гүйцэтгэсэн. Монгол

Улс ФАТФ-ын Ази Нохон далайн бүсийн байгууллагын гишүүн орны хувьд жил бүрийн нэгдүгээр сард багтаагаад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлынхаа тайланг явуулдаг. Энэ хүрээнд бид нэгдүгээр сарын 31-нд тайлангаа цаг хугацаанд явуулсан байгаа. Яг ижил төрлийн тайланг 2018 оны нэгдүгээр сард мөн илгээж байсан. Энэ жилийн тайлан өмнөх жилийнхээс юугаар онцлог вэ гэхээр бид 20 үзүүлэлтээр үнэлгээгээ дээшлүүлэх хүсэлтээ хүргүүлсэн.

Тэгэхээр 2018 онд яагаад энэ хүсэлтээ өгөөгүй юм бэ гэж асуулт гарч ирж болно. Та бүхний мэдэж байгаагчлан бидний 2016 оны тайлан 2017 оны долоодугаар сард батлагдсан байгаа. Тэгэхээр 2018 оны нэг сар гэхэд үнэлгээгээ дээшлүүлэх бодитой ажил хийж амжихааргүй байсан. Тийм учраас 2018 оны нэгдүгээр сард ямар бэлтгэл ажил хийсэн бэ гэдэг талаас нь тайлангаа явуулсан.

2018 онд хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд хамтарч боловсруулсан ажлынхаа тайланг гүйцэтгээд, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан. Мэдээж хууль тогтоомжид өөрчлөлт орсон учраас холбогдох дүрэм, журамд өөрчлөлт орсон. Эдгээр нь Монгол Улсын үнэлгээнд нааштай хандлагыг авчирч байна. Монгол Улсын Засгийн газар, бизнес, санхүүгийн сектор нь асуудлаа ойлгож, зохих арга хэмжээг авсан гэх дохиог олон улсад өгсөн гэж бид найдаж байгаа. Төлөвлөгөөнийхөө гүйцэтгэлийг хянаад, 20 үзүүлэлтээр үнэлгээгээ дээшлүүлэх боломжтой юм байна гэж үзэн, захиалгаа өгсөн. Холбогдох тайлан, материалуудтайгаа явуулсан байгаа. Манай тайланг Ази Номхон далайн бүсийн бүлгээс томилогдсон шинжээчид хянаана. Улмаар хариуныхаа эхний төслийг 3 дугаар сарын сүүлээр ирүүлнэ. Монгол Улс хариугаа хүлээж аваад Хамтын ажиллагааны үндэсний зөвлөлөөр хэлэлцээд, нэмэлт тайлбараа явуулна. Энэ үйл явц 6-7 дугаар сар хүртэл үргэлжлэх юм.

Мэдээж Монгол Улсын харилцан үнэлгээний 2 дахь тайлангийн үр дүн тааруухан гарсан гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Үүнтэй холбоотойгоор 2018 оны 6 дугаар сард болсон ФАТФ-ын ээлжит хурлаар Монгол Улс эрчимтэй хяналтад орсон. Эрчимтэй хяналтад орсон нь бизнес, санхүүгийн мөнгөний урсгалын тогтвортой байдал, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Аливаа улс харилцан үнэлгээнийхээ тайлан дээр муу үнэлгээ авсан тохиолдолд тухайн улсын мөнгө угаах гэмт

хэрэгтэй тэмцэх тогтолцоо нь тааруухан юм байна, өөр улсад олсон гэмт хэргийн орлогоо Монголд угаах боломжтой юм байна гэх сөрөг мэдээлэл өгдөг. Тийм учраас эрчимтэй хяналтад орсон гэдэг нь манай хөрш орнууд, бизнесийн түншүүдэд “Та бүхэн Монгол Улс, Монгол улсад харьяалагдаж байгаа бизнесийн нэгжүүдтэй харилцахдаа хяналтаа чанга байлгах ёстой шүү” гэсэн дохиог өгч байгаа. Тийм учраас аливаа улс орон өөрийнхөө эдийн засгийг өсгөө, дэмжье гэж бодож байгаа бол мөнгө угаах тогтолцоогоо чанга болгодог журамтай юм.

Сүүлийн үед улс орнууд ФАТФ-ын 40 зөвлөмжийн дагуу Иран, Ирактай холбоотой аливаа харилцаа, төлбөр тооцоог нэлээд чангатгах болсон. Бид ч бас энэ жишгийг дагах ёстой. Үүнтэй холбоотойгоор манай улсын гадаад харилцаа, гадаад төлбөр тооцоонд асуудал үүсч байгааг үгүйсгэх аргагүй. Гэхдээ бид үүнийг давж гарах шаардлагатай. Энэ бүхэн монголчууд биднээс шалтгаалах юм. Бид нэгэнт олон улсын эдийн засагт нэг нэгж болоод ажиллаж байгаа тул бид олон улсын дүрмээр л ажиллах ёстой.


NTV:

Хэрэглээний зээлийг хязгаарлах шийдвэртэй холбоотойгоор иргэдийн зээлийн эрэлт арилжааны банкнаас банк бус санхүүгийн салбар руу орох эрсдэл байна уу? Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо энэ тал дээр хамтран ажиллаж байгаа гэсэн. Яг хэрхэн хамтран ажиллаж байгаа талаар тодорхой мэдээлэл өгнө үү.

МБГ-ын МБТХ-ийн захирал Н.УРГАМАЛСУВД:


Макро зохистой бодлогын нэг эрсдэл бол банкны секторт авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээ маань банкны бус сектор руу шилжих эрсдэл өндөр байгаа. Энэ талаар бид Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж байна. Банкууд өнгөрсөн оны 9 дүгээр сарыг хүртэл өр орлогын харьцааг тооцох нэгдсэн аргачлалгүй явж ирсэн. Өөр өөрсдийнхөөрөө, янз бүрийн аргачлалаар тооцоод явж байсан. Нэгдсэн тоон мэдээ ч байхгүй байсан. Санхүүгийн зохицуулах хороотой хамтраад бид өр орлогын харьцааны нэгдсэн статистик үзүүлэлтийг банк бус санхүүгийн байгууллагуудаас гаргуулах чиглэлээр ажиллаж байна. Шаардлагатай тоон мэдээ гарсны дараа бодлогын арга хэмжээг тохируулан авахаар хамтарч ажиллаж байна.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



- **M2** мөнгөний жилийн өсөлт **24.6%** -д хүрч **19.6** их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас **0.9%-иар** буюу **168.3** тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс, **M1** мөнгө **8.7%** (352.2 тэрбум ₮) –иар буурч, **бусад хадгаламж 3.4%** (520.5 тэрбум ₮) –иар өссөн байна.
 - **M1** → ₮-ийн харилцах **376.3** тэрбум ₮-өөр буурч, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө **24.1** тэрбум ₮-өөр өсөв.
 - **Бусад хадгаламж** → \$-ийн харилцах **570.3** тэрбум ₮-өөр өсч, \$-ийн хадгаламж **74** тэрбум ₮-өөр, ₮-ийн хадгаламж **24.2** тэрбум ₮-өөр буурав.

Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




Зураг 3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



- Нийт **M2** мөнгөний нийлүүлэлтийн **51.7%-ийг** ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол **15.7%-ийг** валютын хадгаламж, **15.2%-ийг** ₮-ийн харилцах, **14.2%-ийг** валютын харилцах, үлдсэн **3.3%-ийг** хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ **13.1** их наяд ₮-т хүрснээс **84.4%-ийг** иргэдийн хадгаламж, **15.6%-ийг** байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн **81.3%-ийг**, байгууллагын хадгаламжийн **57.2%-ийг** ₮-ийн хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 4. Нийт хадгаламж



Зураг 5. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл **17.1** их наяд ₮ (Төгрөгийн зээл **14.5** их наяд ₮, Валютын зээл **2.6** их наяд ₮)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **6 тэрбум ₮** буюу **0.04%-иар** буурсан.
- Хэвийн зээл өмнөх сараас **3 тэрбум ₮** буюу **0.02%-иар** өссөн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **13 тэрбум ₮** буюу **2%-иар** буурсан.
- Чанаргүй зээл өмнөх сараас **3.6 тэрбум ₮** буюу **0.2%-иар** өссөн байна.

Зураг 6. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



Зураг 7. Хугацаа хэтэрсэн зээл (салбар бүтэц)




- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 81%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 8. Чанаргүй зээл (салбарын бүтэц)



- Нийт чанаргүй зээлийн 85%-ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 9. Төлбөрийн тэнцлийн статистик, 2018 оны урьдчилсан



Зураг 10. Гадаад хөрөнгө оруулалтын позицын статистик, 2018 оны IV улирал



Зураг 11. Гадаад өрийн статистик, 2018 оны IV улирал





ЖЕРОМЕ ПАУЭЛ БА ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ

ЖЕРОМЕ ПАУЭЛ:

Холбооны Нөөцийн Банкны тэргүүн Жероме Пауэл албан тушаалдаа томилогдоод хэдийнээ нэг жил өнгөрчээ. Энэ оны нэгдүгээр сард тэрбээр Вашингтоны Эдийн засгийн клубд Дэвид Рубенштэйнтэй ярилцаж, өөрийн ажил болон АНУ-ын эдийн засгийн нөхцөл байдлын талаар олон нийттэй хуваалцсан бөгөөд тус ярилцлагадаа төв банкны хараат бус байдлын талаар дурджээ. Бид энэ удаагийн дугаараараа тус ярилцлагын онцлох хэсгүүдийг тоймлон хүргэж байна.

ТӨВЧ НАМТАР

Жероме Пауэл 2018 оны хоёрдугаар сард Америкийн Нэгдсэн Улсын Холбооны Нөөцийн Банкны тэргүүнээр томилогдсон. ХНБ-ны тэргүүн асан Бен Бернанки, Жанет Иеллен нарын адил Жероме Пауэл нь ХНБ-ны Захирлуудын зөвлөлийн гишүүн байсан бөгөөд 7 жилийн хугацаанд тус зөвлөлд олон төрлийн алба хашиж байсан хэдий ч ХНБ-ны сүүлийн 40 жилд томилогдсон анхны эдийн засгийн бус мэргэжилтэй Ерөнхийлөгч болсон юм. ХНБ-ны 16 дахь буюу одоогийн Ерөнхийлөгч АНУ-ын нийслэл болох Вашингтон хотын Колумбын дүүрэгт төрж өссөн. Тэрбээр Принстоны их сургуулийг улс төрийн мэргэжлээр, Жоржтауны их сургуулийг хуулийн докторын чиглэлээр тус тус хамгаалжээ. Улстөрч, хуульч мэргэжилтэй Жероме Пауэл хуулийн салбарт 5 гаруй жил ажиллаж, анх 1984 онд санхүүгийн салбарт орсон бөгөөд хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулж байсан. Түүнчлэн, тэрбээр 1992 онд АНУ-ын Сангийн яаманд ажиллаж байсан бол 2012 онд АНУ-ын ерөнхийлөгч Барак Обама түүнийг анх ХНБ-ны Захирлуудын зөвлөлийн гишүүнээр томилсон нь Жероме Пауэлын ХНБ дахь карьерын эхэлж байсан аж.

Дэвид Рубенштэйн: Та өмнөх ярилцлагууддаа Холбооны нөөцийн банк одоогийн нөхцөл байдал, бодлогын хүүний түвшинд харьцангуй сэтгэл хангалуун байгаа хэмээн дурдсан. Үүнийг зах зээлд оролцогчид хэрхэн задалж ойлгож болох вэ?

Жероме Пауэл: 2018 он АНУ-ын эдийн засгийн хувьд маш сайхан жил болж өнгөрлөө. Эдийн засаг сүүлийн 10 жилд өсөөгүй хэмжээгээр тэллээ. Хөдөлмөрийн захад эерэг өөрчлөлтүүд бий болж, ажилгүйдлийн түвшин сүүлийн 50 жилийн түүхэнд байгаагүй бага түвшиндээ хүрсэн. Цалингийн хэмжээ өсч, ажиллах хүчний оролцоо, бүтээмж нэмэгдсэн. Мөн инфляци бидний зорилт орчимд байна. Бид энэхүү үргэлжилсэн моментумыг оны эхнээс эхэлж анхааралтай ажиглаж байсан.

ДР: Олон нийт бодлогын хүүний сүүлийн хоёр өөрчлөлт төлөвлөгөөний дагуу болсон гэж харж байгаа. Харин цаашид ямар төлөвлөгөө байгаа вэ?

ЖП: Миний бодлоор тийм төлөвлөгөө байдаг гэж шууд хэлэх боломжгүй юм. Бид эдийн засгийн төсөөллийг жилд дөрвөн удаа гаргадаг ба түүн дээр үндэслэж, шийдвэрээ гаргадаг. Сүүлийн хоёр өөрчлөлт бол маш тодорхой ирээдүйн төлөвийг харгалзаж үзсэнээр гаргасан шийдвэр. Ирээдүйд үүсч болзошгүй тодорхой бус байдал байсаар байгаа.

ДР: ХНБ-ны Нээлттэй зах зээлийн зөвлөлийн (Мөнгөний бодлогын эрх бүхий зөвлөл) протокол тодорхой хугацааны дараа олон нийтэд нээлттэй тавигддаг. Яагаад протоколыг хурлын дараа, маргааш нь ч юм уу тавьж болдоггүй юм бэ?

ЖП: Бид мөнгөний бодлогын мэдэгдлийг маш ул суурьтай үздэг учраас үг бүрт нь анхааралтай хандаж, тодорхой бэлтгэсэн форматын дагуу гаргадаг. Энэ нь бодлогын шийдвэрийн үндэслэлийг бүрэн тайлбарлах зорилготой. Протоколын хувьд зөвлөлийн 12 гишүүн бүрийн хэлсэн үг, саналыг тусгаж, тэдгээрийг дахин

боловсруулахад тодорхой хугацаа ордог учраас ийнхүү хоцрогдол үүсдэг. Урьд нь хэдэн сараар хоцордог байсан бол одоо ердөө 3 долоо хоног болсон байгаа. Тэгэхээр протоколд хурлын үеэр хэлсэн зүйлсийг утгыг нь алдагдуулалгүйгээр цэгцлэхэд хугацаа ордог гэж ойлгож болно.

ДР: Протоколоос харахад зөвлөлийн гишүүдэд зөрүүтэй санал байгаа ч шийдвэрийг бүгд санал нэгтгэйгээр гаргалаа гэсэн байна. Тэгэхээр ХНБ-ны Нээлттэй захын зөвлөлийн гишүүд өөр өөр байр суурьтай, хурлын үеэр санал зөрөлдөх зүйл гардаг ч эцэстээ нэг шийдвэрт хүрдэг гэсэн үг үү?

ЖП: Манай тогтолцооны нэг давуу тал бол, институц доторх өөр өөр үзэл бодлыг харгалзаж үздэгт байгаа. Хурлын үеэр 12 гишүүн тус бүр өөрийн эдийн засгийн зөвлөхийн боловсруулсан мэдээлэл дээр үндэслэж, харилцан хэлэлцэж, мэтгэлцэж байж шийдвэр гардаг. Зарим үед маш халуун яриа болдог бөгөөд миний хувьд энэ нь шийдвэр гаргахад маш чухал зүйл юм.

Эцсийн мөчид гишүүд бодлогын саналыг дэмжиж байгаа эсэх дээр санал хураадаг бөгөөд таны ярьж байгаа хурлын хувьд бүгд санал нэгтэй дэмжсэн байна. Хэрэв аль нэг гишүүн дэмжихээс татгалзсан бол протокол дээр дурдагдаж, түүний шалтгаан байр суурийг тодорхой илэрхийлснээр бичигддэг. Миний хувьд Төв банкны тэргүүний хувьд хурлын өмнө бүх гишүүдтэй ярилцаж, харгалзах ямар хүндрэлүүд байгааг тодорхой болгосны дараа бодлогын саналыг

хурлаар оруулах талаар шийдвэр гаргадаг.

ДР: Тэгэхээр хурлын өмнө харилцан ярилцах шатанд зөрүүтэй байр суурь үүсэх үед лоббидох ч юм уу, ямар нэг тохиролцоо хийх тохиолдол гардаг уу?

ЖП: Миний хувьд бүх гишүүдийн бодлыг хүндэтгэн хүлээж авдаг. Энэ нь лоббидох талаарх ойлголт огт биш. Өөрийн зүгээс ямар мэдээлэлтэй байгаа болон гишүүдийн санал ямар байгааг харгалзаж үзэж байж, бодлогын саналыг бий болгодог.

ДР: Таны өмнөх 2 тэргүүн Бен Бернанке, Женет Иеллен нар эдийн засгийн докторын зэрэгтэй. Харин та хуулийн чиглэлээр докторын зэргээ хамгаалсан. Төв банкныг удирдахад эдийн засгийн докторын зэрэггүй байх нь сул тал болдог уу. Нөгөө талаас хувийн хөрөнгө оруулалтын чиглэлээр ихээхэн туршлагатай чинь давуу тал болдог уу?

ЖП: Миний хувьд ямар нэг талаар тийм хүндрэл гардаггүй. Би өөрөө 7 жил ХНБ-ны Захирлуудын Зөвлөлийн гишүүнээр ажиллах хугацаандаа мөнгөний бодлого болон түүний эдийн засгийн нөлөөний талаар судлахад маш их цаг зарцуулсан. Мэдээж эдийн засгийн чиглэлээр докторын зэргээ хамгаалаагүй үед зөвлөлийн гишүүнээр ажиллахын тулд тууштай суралцах хэрэг гарна. Миний хувьд суралцахад бүх амьдралаа зориулсан нэгэн.

Надад танд ярьж өгөх сонирхолтой түүх байна. Би ямар ч бизнесийн мэдлэг болон

туршлагагүй хэрнээ хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулж амжилт олсон нэгэн залууг мэднэ. Тийм ч учраас энэ нь боломжтой юм.

ДР: Таныг томилсон АНУ-ын Ерөнхийлөгч сүүлийн үед Та болон ХНБ-ны бодлогын шийдвэрүүдийн талаар ихээхэн сэтгэл дундуур байгааг илэрхийлэх болсон. Энэ нь танд түвэгтэй санагдаж байна уу?

ЖП: Үгүй л дээ. Бид хийж байгаа зүйлдээ маш их хянамгай ханддаг. Конгресс бидэнд маш тодорхой бөгөөд чухал ажлын чиглэл өгсөн. Энэ нь АНУ-ын иргэн бүрийн амьдралд нөлөөлөхүйц ажил. Бид өөрсдийн бодлогын хэрэгслүүдийг ашиглаж, бүрэн ажил эрхлэлт болон тогтвортой үнийн түвшинг хангахыг зорьж ажилладаг. Бид энэ ажил дээр бусад хамааралгүй хүчин зүйлсийг анхаарч үздэггүй. Бид улс төрийн нөхцөл байдлыг бодлогын шийдвэртээ болон хуралдаа огт тусгадаггүй. Бид улс төрөөс хараат бус ажилладаг.

ДР: АНУ-ын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн ерөнхий зөвлөлийн тэргүүн Ларри Кудлау Ноён Ерөнхийлөгч тантай уулзалт хийж магадгүй гэж мэдэгдсэн. Танд урилга ирсэн үү?

ЖП: Урилга ирээгүй байна. ХНБ-ны тэргүүн улсын Ерөнхийлөгчтэй заримдаа уулзах тохиолдол байдаг. Гэхдээ маш цөөхөн тохиолдол. Мэдээж урилгыг хүлээж аваагүй тохиолдол байхгүй бөгөөд энэ ч зүй бус юм. Тиймээс урилгын талаар ямар нэг мэдээлэл алга байна.

“Бид хийж байгаа зүйлдээ маш их хянамгай ханддаг. Конгресс бидэнд маш тодорхой бөгөөд чухал ажлын чиглэл өгсөн. Энэ нь АНУ-ын иргэн бүрийн амьдралд нөлөөлөхүйц ажил. Бид өөрсдийн бодлогын хэрэгслүүдийг ашиглаж, бүрэн ажил эрхлэлт болон тогтвортой үнийн түвшинг хангахыг зорьж ажилладаг. Бид энэ ажил дээр бусад хамааралгүй хүчин зүйлсийг анхаарч үздэггүй. Бид улс төрийн нөхцөл байдлыг бодлогын шийдвэртээ болон хуралдаа огт тусгадаггүй. Бид улс төрөөс хараат бус ажилладаг.”

2019 он ба ХНБ-ны бодлогын хүү

Ярилцлагын үеэр Жероме Пауэлаас хэд хэдэн удаа АНУ-ын 2019 оны эдийн засгийн төлөв болон ХНБ-ны бодлогын хүүний талаар лавлан асуусан. Жероме Пауэл хариуд нь 2019 он АНУ-ын эдийн засгийн хувьд тогтвортой жил байх бөгөөд эдийн засгийн хямрал болох үндэсгүй хэмээн мэдэгджээ. Гэхдээ Ази болон бусад тивийн эдийн засгийн удаашрал, тодорхой бус байдал, цаашлаад АНУ-ын их хэмжээний төсвийн өр нь эрсдэлийг нэмэгдүүлж байгаа аж. 2018 оны сүүлийн улиралд АНУ-ын санхүүгийн сектор хэлбэлзэлтэй байсан хэдий ч энэ нь хэвийн үзэгдэл бөгөөд тэрбээр үүнд санаа зовохгүй байгааг хэллээ. ХНБ-ны Ерөнхийлөгчийн дурдсанчлан АНУ-ын инфляци 2 хувь орчимд байна хэмээн таамаглаж байгаа ажээ.

Холбооны Нөөцийн Банкны олон нийттэй харилцах байдал

Жероме Пауэлийн Вашингтоны эдийн засгийн клубд өгсөн ярилцлага ХНБ-ны орчин үеийн олон нийттэй харилцах стратеги болон ХНБ-ны үүргийн талаарх сэдвээр өндөрлөв. Тэрбээр хэлэхдээ ХНБ өмнө нь аль болох нууцлаг байхыг илүүд үздэг байсан бол одоо аль болох нээлттэй байхыг эрхэмлэдэг болсон. Учир нь Төв банк нээлттэй байх тусам олон нийт Төв банкинд итгэл хүлээлгэж, Төв банк хүлээлтийг зүй зохистой удирдах боломжтой болдог байна. Иймд, ХНБ хэвлэлийн бага хурлыг тухай бүр хийж, МБХ-ны протоколыг олон нийтэд цаг алдалгүй хүргэж, олон нийтийн санал хүсэлтийг бодлогын хүрээнд хүлээж авдаг хэмээн Жероме Пауэл мэдэгдсэн.


Яагаад Төв банкнууд хараат бус байх хэрэгтэй вэ?

Жероме Пауэлийн Вашингтоны эдийн засгийн клубтэй цагаа олсон ярилцлага хийлээ хэмээн ажиглагчид үзэж байна. Учир нь Турк, Энэтхэг зэрэг цөөнгүй дэлхийн төв банкнууд хараат бус байдлаа алдах аюулд ороод байгаа билээ. Төв банк хараат бус байдлаа алдвал улс төрчид өөрсдийн ашиг сонирхолдоо нийцүүлэн Төв банкинд нөлөөлөх гэж оролддог. Ингэснээр тухайн улсын инфляц, валютын ханш зэрэг нь тогтворгүй болж, эдийн засаг нь хямралд өртөх аюулд ордог юм. Түүнчлэн, хөрөнгө оруулагчид хараат бус төв банктай байсан тохиолдолд тухайн улсыг тогтворгүй, найдваргүй хэмээн үзэж хөрөнгө оруулалтаа татаж, хөрөнгө оруулахаас зайлсхийдэг. Төв банкны хараат бус байдлыг олон судлаачид дэмждэг бөгөөд судалгаагаар төв банкнууд хараат бус байхдаа илүү оновчтой, ирээдүй рүү чиглэсэн шийдвэр гаргадаг хэмээн дүгнэжээ.

Эх сурвалж: <https://www.cnn.com/video/2019/01/10/watch-fed-chairs-jerome-powells-full-interview-at-the-economic-club-of-washington.html>

<https://www.bbc.com/news/business-46763683>

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 26/II ӨДРИЙН БАЙДЛААР)**



WORLD ECONOMIC FORUM

ДАВОС 2019

ЮУ ХЭЛЭЛЦЭВ?

Жил бүрийн 1-р сард дэлхийн төр, нийгэм, эдийн засгийн орой болсон зүтгэлтнүүд чуулж, тухайн цаг үеийнхээ асуудлыг болон олон улсын эдийн засагт цаашид тулгарч болзошгүй эрсдэлүүдийг хэлэлцдэг билээ. Уг чуулга уулзалтыг Дэлхийн эдийн засгийн форум гэх бөгөөд Швейцар Улсын Давос хотноо зохион байгуулагддаг уламжлалтай. 49 дэх жилдээ болсон 2019 оны Дэлхийн эдийн засгийн форум сенсаци багатай болж өнгөрсөн боловч өнөө цагт олон улсад тулгараад байгаа олон асуудлыг хөндлөө. Энэ үеэр дэлхийн эдийн засгийн хоёр их хүчний хоорондын худалдааны зөрчилдөөн, Их Британи Европын холбооноос гарахад үүсч болзошгүй доргио гээд олон нийтийн дунд халуун сэдэв болоод байгаа асуудлуудыг хэлэлцсэн ч, тус чуулга уулзалтын үеэр зонхилж байсан сэдвийг Монголбанкны мэдээлэл товхимлын ээлжит дугаарын олон улсын эдийн засаг буланд онцолж байна.

Энэ жилийн дэлхийн эдийн засгийн форум 2019 оны 1-р сарын 22-оос 25-нд тохиож, чуулганы гол сэдвийг “Глобалчлал” хэмээн томъёолсон байна. Дэлхийн эдийн засгийн форумыг үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гүйцэтгэх тэргүүн Клаус Шваб хэлсэн үгэндээ ч үүнийг онцолсон. Тэрбээр дараах зүйлсийг тодотгосон аж. Тодруулбал, өнгөрсөн зууны 2-дугаар хагасаас эхэлж дэлхий нийтээрээ хамтарч нэг ирээдүйг цогцлоохоор зорих болсон. Харамсалтай нь дэлхийн санхүүгийн хямрал нүүрлэснээс хойш 10 жил өнгөрсөн ч улс орны иргэдийн итгэл сэргэхгүй, эдийн засагтаа сэтгэл дундуур байх болжээ. Гол шалтгаан нь эдийн засаг сэргэсэн ч хүртээмжтэй байдлыг хангаж чадаагүй байна. Иргэдийн итгэл сулрахын цагт популизм хамгийн тааламжтай зүйл болон хувирдаг аж. Үүнийг ч улс орны иргэдийн сонголт, Брексит, худалдааны маргаан зэргээр нотолж болох юм.

Глобалчлал 4.0

Форумын үеэр хэлэлцсэн нэг сэдэв бол Глобалчлал 4.0 байлаа. Юун түрүүнд глобалчлал болон глобализм гэсэн хоёр ойлголтыг тодруулж тайлбарлах нь зүйтэй болов уу. Глобалчлал гэдэг нь технологийн шинэчлэл, хүмүүсийн үзэл санаа, санаачлагаас үүдэлтэйгээр дэлхий хавтгай болох үзэгдэл юм. Харин глобализм гэдэг нь неолиберал идеологи буюу дэлхий нийтийн эрх ашгийг өөрийн улс орны эрх ашгаас түрүүнд тавих явдал аж. Санхүүгийн хямралын үр дүнд дэлхий нийтийг засаглалын бүтэцдээ эргэлзэхэд хүргэсэн. Өөрөөр хэлбэл, олон нийт, иргэд улсынхаа эрх мэдлийг эргүүлэн авч, нэгдмэл урсгалаас гарч, дэлхийн хамтын ажиллагаанд бие даасан байдлыг хангахыг эрмэлзэх болсон аж. Гэхдээ үүнийг протекционист бодлого, үндсэрхэг улс төртэй хэрхэвч хольж ойлгож болохгүй. Харин ч эсрэгээр иргэдийн энэхүү хүсэл эрмэлзэлд тулгуурлаж, улс орны бие даасан байдлыг хадгалах зарчмаар олон улсын хамтын ажиллагааг ханган өргөжүүлж, удирдагчид иргэдтэйгээ нэг зүгт хандахуйц бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх нь зохистой юм.

Цаашлаад технологийн дэвшил нь аж үйлдвэрийн 4-р хувьсгал (АҮХ4) гэгчийг бий болгож байна. Өнөө цагт экологи, олон талт худалдаа, тэгш байдлыг онцгойлон анхаарах боллоо. Эдгээр нь глобалчлалын шинэ эрин үе рүү чиглүүлж байна. Ялангуяа, чөлөөт эдийн засгийн өрсөлдөөн нь тэгш бус байдлыг бий болгож байхад АҮХ4 хэмээх бизнесийн загварыг шийдэл хэмээн харж байгаа.

Тэгш бус байдлыг арилгахын тулд бид бүхэн инноваци бүхий эдийн засгийг хүлээн зөвшөөрч, олон нийтийн итгэлийг сэргээхийн тулд олон улсад шинэ норм, стандарт, бодлого, конвенцуудын шаардлагыг бий болгож байна. Глобалчлал 4.0 нь үүд хаалга

тогшоод ирэх үед бид бэлтгэл багатай байна. Тиймээс ч хоцрогдсон сэтгэлгээг халж, өнөөгийн замбараагүй байдал цаашид үргэлжлэхээс сэргийлэх, шинэ боломжуудыг суурь болгох зарчмыг үгүйлж байна.

Бид бүхэн шинэ чиг хандлагыг эдийн засагт хөгжүүлэхдээ ялагч, ялагдагчтай тоглоом (zero sum game) биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь чөлөөт худалдаа ба протекционизм, технологи ба ажлын байр, цагаачлал ба иргэдийн хамгаалал, хөгжил ба тэгш бус байдал гэсэн ялгааны тухай биш юм. Энэ нь илүүтэй бүх талын ашиг сонирхлыг харгалзаж үзэх “эсвэл” гэсэн үгнээс илүүтэй “хамтаар” гэсэн агуулгатай байх тухай ойлголт юм.

Байгаль орчны асуудлууд

Давосын чуулга уулзалт эхлэхээс өмнө оролцогчдын дунд хэлэлцэгдэж эхэлсэн өөр нэг чухал асуудал бол байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн тухай юм. 2019 оны Дэлхий нийтийн эрсдэлийн тайланд “Дэлхий нийт өөрийн мөхөл рүүгээ унтаагаараа алхаж байна” хэмээн хурцаар шүүмжилсэн нь эдгээр хэлэлцүүлгийн сэдэл болсон аж. Уг тайланд мөн байгаль орчны эрсдэл, хүн амын эрүүл мэнд, эдийн засгийн өсөлт, аюулгүй байдал гэх зэрэгт зовиноход хүргэсэн.



Дэлхийн эдийн засгийн форумын “Болор цом” гэх хүндэт шагналыг Сэр Дэвид Атенборыгийн байгаль эх дэлхийг хайрлах манлайлалд оруулсан хувь нэмрийг нь үнэлж олголоо. Ерөнхий дүр зургаар нь харвал байгаль орчны асуудлуудаар олон хэлэлцүүлэг өрнөсөн нь энэ жилийн онцлог байлаа. Ялангуяа, Дэлхийн эдийн засгийн форумын глобал шейперс буюу залуу манлайлагч нар голлох хэлэлцүүлгүүдийг хамтран удирдсанаар залуу үе юуг илүүтэйгээр анхаарч байгааг

харуулсан юм. Хөгжлийг бий болгох явцад байгаль орчинд маш их хохирол учруулж, хэмжээлж баршгүй зардал, нөхөн сэргээлт, эрүүл мэндийн асуудлуудыг дагуулж байгаад залуу үе сэтгэл зовинож байгаа аж.

Өөр нэг анхаарууштай зүйл нь дэлхий нийтийн хэрэглээ цахилгаан хэрэгслийн хог хаягдал – “E waste”-ийг ихээр бий болгож байна. Африк тив цахилгаан хэрэгслийн хог хаягдлын төв цэг болж байгаа ба Dell, Microsoft, HP, Phillips зэрэг дэлхийд тэргүүлэх 10 электроник компаниуд хог хаягдлыг бууруулахад бүх нөөц бололцоогоо ашиглахыг энэ үеэр амлалаа.

Йелийн их сургуулийн Стерлинг профессор Виллиам Нордхаус нь эдийн засгийн урт хугацааны өөрчлөлтөд уур амьсгалын нөлөөг судалснаараа эдийн засгийн салбар дахь Нобелийн шагналыг 2018 онд хүртсэн. Мөн 2018 оны 10 дугаар сард гарсан Засгийн газар хоорондын уур амьсгалын өөрчлөлтийн тайланд дэлхийн дулаарлыг 1.5°с градуст хадгалахад 12 жил үлдсэн, WWE буюу дэлхийн байгаль хамгаалах сангаас гаргасан тайланд 1980 оноос хойш дэлхийн амьтны зүйл 60 хүртэл хувиар буурсан гэх мэт сэрдхийлгэм тоонууд энэ үеэр олны анхаарлыг татлаа. Энэ бүхэн юуг илэрхийлж байна вэ гэхээр, хүссэн хүсээгүй урт хугацааны, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгохын тулд байгаль орчныг хамгаалах нь зайлшгүй шаардлагатай юм.

Ийнхүү дэлхий нийтээр цаашид хамтарч ажиллах шаардлага үүсээд байгааг оролцогч тал бүр онцолж байсан. 2020 онд тус форумын 50 жилийн ой тохионо. Ирэх жилийн хэлэлцэх асуудлуудад дээр дурдсан хоёр асуудал өргөн хүрээнд дахин хэлэлцэгдэх нь дамжиггүй. Нөгөө талаас 2020 он гэхэд энэ хоёр чиглэлээр өргөн хэмжээний арга хэмжээ авахгүй бол хэт оройтсон байх болно.

Эх сурвалж:

<https://www.weforum.org/agenda/2018/11/globalization-4-what-does-it-mean-how-it-will-benefit-everyone/>

<https://www.weforum.org/agenda/2019/01/the-environment-was-high-on-the-agenda-in-davos-but-what-actually-happened/>

<https://www.forbes.com/sites/lbsbusinessstrategyreview/2019/02/12/five-insights-from-davos-on-the-future-of-work/#43ec8b9f104f>



ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛД ТӨВ БАНКУУДЫН БОДЛОГЫН ХҮҮ

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг
"МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн 10 дахь дугаараас онцлов.

Б.БУЯН, Ц.БАТМӨНХ

Хураангуй: Геополитикийн зарим асуудал, түүний дэлхийн эдийн засаг, хөрөнгийн урсгалд үзүүлж байгаа нөлөөлөл, даяарчлал, төв банкуудын бодлогын хүү, зарим улс орны эдийн засгийн байдал, том гүрнүүд хэрхэн арга хэмжээ авч ажиллаж байгааг товчхон танилцуулахыг зорилго.

1. Deglobalization

Сүүлийн жилүүдэд "Deglobalization" гэдэг ухагдахуун дахин хүчээ авч олон улсын судлаачид энэ талаар бүтээл, нийтлэлдээ ихээр дурдах болсон байна. Тухайлбал, Монгол Улсын Аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс гаргасан "Олон улсын аюулгүй байдлын тогтолцоон дахь тектоник шилжилт" нийтлэлд дэлхий даяар "дэлхий-нэг тосгон" гэсэн ойлголтоос ухарч, "Deglobalization" буюу Даяарчлалын ухралт хэмээх шинж тэмдэг илэрч байгаа талаар өгүүлжээ.

"Deglobalization" гэдгийг "Дэлхийн улс орнуудын хоорондын харилцан хамаарал болон интеграци буурах үйл явц юм" гэж тодорхойлсон байдаг. Энэхүү үйл явцыг түүхийн тодорхой мөчлөгт дэлхийн улс орнуудын худалдаа, эдийн засгийн харилцаа, хөрөнгө оруулалт буурснаар тайлбарласан байна. Үүний хамгийн том жишээ нь 1914-1945 онд тохиолдож байсан бөгөөд дэлхийн II дайн, эдийн засгийн хямрал, худалдааны хямрал зэрэг нь хөрөнгө оруулагчдын санааг зовоож, тодорхойгүй байдалд хүргэж байсан ажээ.

АНУ-ын зарим судлаач "Даяарчлалын үзэл, түүнийг хөхүүлэн дэмжигч олон улсын харилцааны хэм хэмжээ, эрх зүйн тулгуур зарчим, реалполитикийн тооцоо, тоглоомын онол дээр суурилсан их гүрнүүдийн хүчний тэнцвэрийг хангах бодлого байр сууриа алдсанаар 1970-аад онд ерөнхийлөгч Ричард Никсон, түүний үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх Хенри Киссинжер нарын ЗХУ, БНХАУ-ын хувьд баримталж, амжилттай гэж хэлж болохоор хэрэгжүүлсэн хүчний тэнцвэрийн бодлого нь Трампын засаг захиргааны өнгөн дээр сэргэнэ" гэсэн байна.

Их гүрнүүдийн геополитик, гео эдийн засгийн хандлага, хүчний хуваарилалт, таталцал, түлхэлцэл нь янз бүрийн хэлбэрээр илэрч байгаагийн дээр хүчний тэнцвэр алдагдах, улмаар хүчний ямар харьцаа тогтох нь бий болсон өрсөлдөөн, сэргөлдөөн, авсан арга хэмжээ, түүний үр дагавраас шалтгаалах энэ цаг үед даяарчлалын ухралт, түүний зарим шинж тэмдэг илрээд байна. Тухайлбал, Трампын "Америк нэгдүгээрт" уриа, түүнийг дагасан худалдааны дайн, БНХАУ-ын дотоодын эдийн засгаа дэмжсэн бодлого, "Бүс ба зам" санаачилга, юанийг төлбөр тооцооны гол валют болгох бодлого, Их Британийн "Brexit", ОХУ-БНХАУ-Монгол Улсын хамтарсан цэргийн сургуулилалт, зэвсгийн хүчээ нэмэгдүүлж, шинэ технологийг эрэлхийлэх, эрчим хүчний гол тоглогч болох амбиц, "Свифт" олон улсын төлбөр тооцооноос гадна төлбөр тооцооны шинэ хэрэгслийг гаргах санаачилга, "Германы төлөө Альтернатив", Францын "Үндэсний фронт", Италийн "Таван од" хөдөлгөөн буюу цагаач, дүрвэгчдийн талаар хатуу байр суурь баримтлах бодлого, Туркийн үндсэрхэг удирдагчийн бодлого, түүний Газрын тосны тээврийн төв (hub) болох амбиц, хоёр Солонгосын нэгдэл, БНАСАУ-ын баялаг, БНСУ-ын эх газартай төмөр замаар холбогдох алсын хараа зэргийг нэрлэж болохоор байна.

2. Улс, орнуудын хөрөнгийн урсгал, эдийн засгийн зарим үзүүлэлт

Улс, орнуудын хөрөнгийн урсгалын талаарх мэдээллийг <http://www.tradingeconomics.com> цахим хуудсаас авч харахад 114 улс орны хөрөнгийн урсгалыг сүүлийн нэг жилийн байдлаар үзэхэд, 63 нь эерэг урсгалтай, 48 нь сөрөг буюу хасах дүнтэй гарсан байна.

АНУ-ын нэг сарын хугацааны хөрөнгийн урсгал 108 тэрбум ам.доллар, ХБНГУ-ынх 14.5 тэрбум евро, ИБУИНВУ-ын улирлын хөрөнгийн урсгал 13.8 тэрбум фунт стерлинг, ОХУ-ынх 20.9 тэрбум ам.доллар, Японых 19.1 тэрбум иен, Тайванийнх 14.7 тэрбум ам.доллар, Саудын Арабынх 14.6 тэрбум ам.доллар, Ирландынх 14.1 тэрбум ам.доллар, Италийнх 10.3 тэрбум евро, БНСУ-ынх 7.2

тэрбум ам.доллараар тус тус эерэг гарч тэргүүлж байна.

2.1. АНУ-ын татварын бодлого, түүний хөрөнгийн урсгалд нөлөөлсөн нь

АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ) бодлогын хүүгээ өсгөснөөр хөрөнгийн урсгал АНУ-д чиглэснээс гадна татварын реформ (Tax Cuts and Jobs Act (TCJA) 2018 оны эхээр хийгдсэний дараа АНУ-ын том компаниуд гадаад дахь орлогоос олсон хөрөнгөө эх орондоо татан төвлөрүүлсэн байна.

2.2. БНХАУ-ын Ардын банк, Японы Төв банкны своп хэлцэл

БНХАУ-ын Ардын банк болон Японы Төв банкны хооронд гурван их наяд иен (30 тэрбум ам.доллар)-тэй тэнцэх иен/юаний своп хэлцэл хийнэ гэж мэдэгджээ. Өмнөх хэлэлцээрээс арав дахин өндөр дүнтэй энэхүү хэлэлцээрийг худалдааны эргэлт, харилцан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан хийхээр хоёр тал тохирчээ. Өмнөх своп хэлцэл нь 2002-2013 онд хэрэгжиж байсан бөгөөд Сенкаку арлын маргаанаас болж хэлэлцээрийг сунгахгүйгээр цуцалсан байна. Бизнес эрхлэгчдээс ханшийн хямрал, төлбөр тооцооны дутагдал гарах үед ашиглах энэхүү своп хэлцлийн хэлэлцээрийг сэргээх хүсэлт ихээхэн ирж байсан бөгөөд тэд БНХАУ дахь Японы компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд дэм болно гэж үзсэн байна. Мөн уг хэлэлцээр нь хоёр орны 2008 онд зогсоосон байгалийн хийн төслийг үргэлжлүүлэх хэлэлцээг эхлүүлэх, Сенкаку арлын хурцадмал байдлыг зөөлрүүлэх бодлогын эхлэл, БНХАУ-ын юанийн хэрэглээг дэмжиж, долларжилтыг багасгах бодлогын нэг хэсэг гэж шинжээчид үзэж байна.

2.3. Венесуэл улс ам. доллараас татгалзлаа.

Венесуэл улс нь байгалийн хийн нөөцөөр дэлхийд 8-д, газрын тосны үйлдвэрлэлээр 10-т жагсаж байна. Тус орны эдийн засгийн уналтад популист бодлого, 2014-2015 онд газрын тосны үнэ 100-аас 50 ам.доллар хүртэл унасан, эдийн засгийн дархлаа нь суларсан, Голланд өвчинд нэрвэгдсэн зэрэг нь нөлөөлж, одоогоор хүн амын 90 хувь нь ядуу, 75 хувь нь хүнс, тэжээлийн дутагдалд орсон байна. Өнгөрсөн есдүгээр сард тус улс ам.доллараас татгалзаж байгаа талаар олон улсад мэдэгдээд, газрын тос, байгалийн хийн худалдааг зөвхөн еврогоор хийж, ам.доллараас татгалзахыг уриалсан байна.

3. Төв банкуудын бодлогын хүү, ханш, хувьцаа

2018 оны гуравдугаар улиралд нийт 29 орны Төв банкны бодлогын хүүнд өөрчлөлт орсон байгаагаас бодлогын хүүг бууруулсан Төв банк 6, бодлогын хүүг өсгөсөн Төв банк 23 байна.

Хүснэгт 1. Төв банкуудын бодлогын хүү, хөрөнгийн урсгалд орсон өөрчлөлт (хувиар, нэгж хувиар, тухайн валютаар)

д/д	Улс орнууд	Хүү	Өөрчлөлт	Огноо	Жилийн өөрчлөлт
1.	Дэлхийн дундаж	6.41%	0.12%	15-10-18	41.5%
2.	Ангол	16.5%	-1.5%	17-7-18	-1.5%
3.	ИБУИНВУ	0.75%	0.25%	2-8-18	0.25%
4.	АНУ	2.25%	0.25%	26-9-18	0.75%
5.	Арабын Нэгдсэн Улс	3.0%	0.25%	26-9-18	0.75%
6.	Аргентин	65.0%	5.0%	28-9-18	36.25%
7.	Бахрейн	2.5%	0.25%	26-9-18	0.75%
8.	Доминикан	5.5%	0.25%	26-7-18	0.25%
9.	Гүрж	7.0%	-0.25%	25-7-18	-0.25%
10.	Йордан	4.5%	0.25%	30-9-18	0.75%
11.	Индонези	5.5%	0.25%	27-9-18	1.5%
12.	Казакстан	9.25%	0.25%	15-10-18	-1.0%
13.	Канад	1.5%	0.25%	11-7-18	0.5%
14.	Кени	9.0%	-0.5%	30-7-18	-1.0%
15.	Макао	2.5%	0.25%	27-9-18	0.75%
16.	Македони	2.75%	-0.25%	14-8-18	-0.5%
17.	Мозамбик	15.0%	-0.75%	30-8-18	-4.50%
18.	Монгол	10.0%	-1.0%	23-3-18	-1.0%
19.	Норвеги	0.75%	0.25%	20-9-18	0.25%
20.	ОХУ	7.5%	0.25%	14-9-18	-0.25%
21.	Пакистан	8.5%	1.0%	29-9-18	2.75%
22.	Саудын Араб	2.75%	0.25%	26-9-18	0.75%
23.	Сиерра Лион	16.5%	1.5%	3-7-18	2.0%
24.	Турк	24.0%	6.25%	13-9-18	16.0%
25.	Чех	1.5%	0.25%	26-9-18	1.0%
26.	Уганда	10.0%	1.0%	3-10-18	0.5%
27.	Украйн	18.0%	0.5%	6-9-18	3.5%
28.	Узбекистан	16.00%	2.0%	22-9-18	2.0%
29.	Филиппин	4.5%	0.5%	27-9-18	1.5%
30.	Хонгконг	2.5%	0.25%	27-9-18	0.75%
31.	БНХАУ	4.35%	-0.25%	23-10-15	0%
32.	Энэтхэг	6.5%	0.25%	1-8-18	0.5%

Эх сурвалж: <http://centralbanknews.info>

Зарим анхаарал татахуйц өөрчлөлтөөс дурдахад, АНУ-ын ХНБ бодлогын хүүг 0.25 нэгж хувиар (оны эхнээс 0.75 нэгж хувиар), ИБУИНВУ 0.25 нэгж хувиар, ОХУ 0.25 нэгж хувиар (оны эхнээс 0.25 нэгж хувиар буурсан), Аргентин 5.0 нэгж хувиар (оны эхнээс 36.25 нэгж хувиар өссөн), Турк улс 6.25 нэгж хувиар (оны эхнээс 16.0 нэгж хувиар) тус тус өсгөсөн байхад дэлхийн дундаж оны эхнээс 41.5 нэгж хувиар, сүүлийн улиралд 0.12 нэгж хувиар өссөн байна.

4. Голлох түүхий эдийн үнийн таамаглал


4.1. Нүүрсний үнэ

Deutsche Bank болон Royal Bank of Scotland нүүрсний салбарт шинээр зээл олгохоос татгалзах хандлагатай

байгаа бөгөөд Citi банкнаас хийсэн судалгаагаар, эдгээр банкны нүүрсний салбарт олгож буй зээлийн хэмжээ 2012-2018 онд 80 хувиар буюу 10 тэрбумаас 2 тэрбум ам.доллар хүртэл багассан байна.

БНХАУ-ын Засгийн газраас байгаль орчин, агаарын бохирдлыг багасгах зорилгоор хэрэгжүүлж буй бодлогын үр дүн, нүүрсний зах зээлийн хөрөнгө оруулалтын бууралтаас улбаалан олборлолт буурснаар сүүлийн 3 жилийн хугацаанд нүүрсний үнэ 50 хувиар өсөөд байна. Азийн улс орнуудад болж буй хэт халалт болон Индонез, ӨАБНУ-д нүүрлэсэн үерийн улмаас нүүрсний нийлүүлэлт, экспортын хэмжээ багасч, нүүрсний үнийн өсөлтөд нөлөөлсөн байна. Цаашид нүүрсний нийлүүлэлт тогтворжиж, нүүрсний эрэлт багасах чиг хандлагатай байна.

Зураг 1. Нүүрсний үнэ (сүүлийн 5 жилийн байдлаар)



Эх сурвалж: *Financial times*

Өнөөдрийн байдлаар дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 1/3-ийг нүүрсний эх үүсвэрээр хангаж байна.

5. Монгол Улсад үзүүлэх нөлөө

“Америк нэгдүгээрт” уриа, АНУ-ын бодлогын хүүний өсөлт, худалдааны дайны үр нөлөө нь компаниудын санхүүжилт, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж, олон компанийн ашигт ажиллагаанд, улмаар хөрөнгийн биржийн бууралтад нөлөөлсөн, түүнийг дагасан хөрөнгийн урсгал, БНХАУ-ын юанийн хэрэглээг төлбөр, тооцоонд түлхүү ашиглах бодлого, “Бүс ба зам” санаачилгыг урагшлуулах бодлого, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины ам.долларын бүсээс гарах санаачилга, дэлхийн газрын тосны томоохон үйлдвэрлэгч Венесуэл улс ам.доллараас татгалзаж байгаагаар албан ёсоор зарласан явдал, Япон-Хятадын ам.долларын хэрэглээг бууруулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хийж байгаа своп хэлэлцээр, АНУ-ын шар буурцагны хэрэглээг бууруулах, улмаар татгалзах БНХАУ-ын бодлого зэрэг нь даяарчлалын ухралтын шинж тэмдгүүдийг агуулж байгаа нь хамгийн

багадаа дэлхийн хүн амын хоёр тэрбум хүнд хүрч, нөлөөллөө үзүүлж байгаа хэдий ч Монгол Улсын эдийн засагт шууд нөлөөлөх нөлөөлөл нь илт харагдахгүй байна. Гэвч өрнөж буй зарим үйл явдлын дам нөлөөг судлан үзэх нь зүйтэй юм. АНУ-ын ХНБ-ны бодлогын хүүний өсөлт нь АНУ руу чиглэж байгаа хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлж, санхүүжилтийн зардлыг өсгөж байгаа нь илт байна. Манай орны хувьд үүнийг АНУ-ын бондын хүүний өсөлт, Хөгжлийн банкны олон улсад гаргасан сүүлийн бондын санхүүжилтийн зардлын хүү (7.25 хувь) зэргээс харж болохоор байна. Дунд хугацаанд буюу 2020, 2021 онд дараагийн төлбөр гарахаар хүлээгдэж байгааг харахад, эдийн засгийн дотоод нөөц бололцоогоор экспортыг дэмжсэн бодлого явуулж нөөцөө бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Мөн АНУ, БНХАУ-ын худалдааны дайн үргэлжилж, протекционист бодлого нь улс, үндэстэн дамнан даамжирвал улс орнуудын дархлааг сорьсон он жил болж өрнөхөөр харагдаж байна. БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилгын үргэлжлэл, түүнийг дагасан хөрөнгө оруулалт нэмэгдэх ач холбогдолтой хэдий ч зарим улс орон хөрөнгө оруулалт, түүний удирдлагыг оновч муутай хэрэгжүүлэхэд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компаниудад стратегийн ач холбогдолтой, баялаг төслүүдийг алдах эрсдэлтэй байна. Нөгөөтэйгүүр, АНУ-ын хөрөнгө оруулалттай компани байгуулах замаар БНХАУ-ын олон улс дахь хөрөнгө оруулалтын болон зөөлөн хүчний бодлогыг сулруулах арга хэмжээ авах нь хөрөнгийн урсгалыг ямар нэгэн хэмжээнд эргээд хөгжиж буй зах зээл рүү чиглүүлэхэд нааштай байж болох юм.

Монгол Улсын импортод голлох байр суурийг эзлэх газрын тосны үнэ, экспортын гол эх үүсвэр болох нүүрсний үнэ зэрэг нь манай эдийн засгийн байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл болж байна. Иймд ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путины дурдсанчлан: “... үндэсний мөнгөн тэмдэгтийн хэлбэлзлийг бууруулах санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх, худалдааны төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх, эцсийн дүнд ам.долларын хэрэглээг төлбөр тооцоонд хязгаарлах, улмаар халах чиглэл рүү явах”, мөн БНХАУ-ын юанийн хэрэглээг дэмжсэн бодлогыг сайтар ажиглаж, Монгол Улсын эдийн засгийг дэмжсэн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийг өөрийгөө тэтгэх чадамжтай болгох зэрэг асуудал чухал ач холбогдолтой байна.

САНХҮҮГИЙН ЛУЙВРААС БОЛГООМЖИЛ: ҮНЭГҮЙ БЯСЛАГ ХАВХАНД Л БИЙ

Иргэн та өөрийн цахим мэдээлэл, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хамгаалж, санхүүгийн луйвраас урьдчилан сэргийлэхийн тулд дараах хэд хэдэн асуудалд үргэлж анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүнд:

1. Төлбөрийн картын аюулгүй байдлыг анхаарах:

- Картын нууц үг, пин кодоо найдвартай хадгалах. Дэлгүүр, олон нийтийн газарт явахдаа үйлчлүүлэгч байгууллагын хүссэнээр нууц үгээ ил задгай хэлэхгүй байх, зөвхөн өөрөө нууц кодоо хийж, баталгаажуулснаар худалдан авалт хийх.
- АТМ-аар гүйлгээ хийх үеийн аюулгүй байдлаа хангах. Нууц пин кодыг оруулахдаа шаардлагатай бол гараараа далдалж байгаад оруулах хэрэгтэй. Мөн бусад үйлчлүүлэгч таны дансны хуулга, эсвэл пин кодыг харах зэргээс урьдчилан сэргийлнэ үү.
- Компьютерээ хамгаалагдсан эсэхийг шалгах. Таны компьютер таны мэдээллийг тодорхой хэмжээнд агуулж байгаа. Ялангуяа аливаа

цахим гүйлгээ, төлбөр тооцоотой холбоотой ажлаа компьютер дээр гүйцэтгэж байгаа бол та компьютерээ маш найдвартай нууц үгээр хамгаалаарай.

Онлайн худалдан авалт хийхдээ болгоомжтой байх. Мэдээж онлайн худалдан авалт хийхэд танаас E-token code, картын нээлгэсэн болон дуусах хугацаа гэх зэрэг мэдээллийг шаардана. Найдвартай, аюулгүй онлайн худалдана авалт хийж байгаа бол энэ асуудал биш. Гэхдээ иргэд мэдлэг, мэдээлэлгүйг далимдуулж, онлайн худалдан авалт нэрээр цахим луйвар хийдэг элдэв төрлийн вэб сайтууд ч бий гэдгийг анхаарах хэрэгтэй. Тэд таны картын мэдээллийг хормын дотор авч, дансыг тань хоослох вий.

Банкны хуулгаа шалгах. Таныг өөрөө ч мэдээгүй байхад данснаас чинь ямар нэгэн гүйлгээ, шилжүүлэг гарсан байх вий. Тиймээс дансны хуулгаа тогтмол шалгаж, хэрэв таны хийгээгүй гүйлгээ хийгдсэн байвал банкинд, эсвэл хууль хяналтын байгууллагад хандан яаралтай шалгуулах нь зөв юм.



2. Гэнэтийн цахим шуудангаас болгоомжил:

Луйврын цахим шуудангийн жишээ нь таныг дансны мэдээллийн аюулгүй байдалдаа баталгаажуулалт хийхийг хүссэн байдлаар ирэх нь элбэг. Ингэхдээ таны харилцдаг банкны албан ёсны цахим шуудангийн хаяг дээр хүнд анзаарагдахааргүй багахан өөрчлөлт хийж илгээдэг байна. Нэг цэг, эсвэл нэг үсэг илүү бичигдсэн байхад л луйврын шуудан болж хувирна гэдгийг анхаараарай. Иймд санхүүгийн аливаа асуудалтай холбоотой цахим шуудан танд ирсэн бол ирсэн и-мэйл хаягийг маш сайн нягталж, шаардлагатай бол тухайн харилцаж буй банкнаасаа утсаар ярьж, тодруулахад ч гэмгүй юм.

Луйврын цахим шуудангийн жишээ.

Хэнээс: no_reply@emailonline.yourbank.com

Агуулга: Дансны статус

Хүндэт (Таны банкны нэр) харилцагч танаа,

Таны дансанд сүүлд хийгдсэн гүйлгээтэй холбогдуулан бид дараах аюулгүй байдлын шинэ шаардлагыг танилцуулж байна. Таны аюулгүй байдлыг хангахын тулд таны дансанд нэвтрэхийг түр хугацаагаар хаалаа. Танаас өөр хүн таны дансанд нэвтрэх боломжийг хязгаарлахын тулд таны банк дансыг тань хамгаалж байна.

Та өөр төхөөрөмж, эсвэл байршлаас өөрийнхөө данс руу нэвтэрсэн учраас та энэхүү мессежийг хүлээн авсан болно. Хэрэв ийнхүү нэвтэрсэн хүн нь та бол таны данс руу нэвтрэх эрх сэргээгдэх болно. Хувийн дансны мэдээллээ хамгаалахын тулд дараах зааварчилгааны дагуу нэн даруй нэвтэрч баталгаажуулалт хийнэ үү.

Дансаа баталгаажуулахын тулд энд дарна уу.

Сайн сайхныг хүссэн,

Картер Франке

Маркетингийн Ерөнхий Ажилтан

Карт эзэмшигчдийн үйлчилгээ

ЗАРИМ НИЙТЛЭГ САНХҮҮГИЙН ЛУЙВАР



“Skimming” буюу мэдээлэл хулгайлах



“Phishing” буюу цахим халдлага



Урьдчилгаа төлбөрийн луйвар.



Төлбөртэй тусгай дугаар



Шагнал, сугалаа, уралдаанд хожлоо, тасалбартай холбоотой луйвар


ТА ГОМДОЛТОЙ БАЙВАЛ ЯАХ ВЭ?

1. Холбогдох бүх бичиг баримтаа цуглуулах
2. Санхүүгийн байгууллагад гомдол гаргах
 - Таны нэр, хаяг;
 - Та ямар учраас шударга бус хандлаа гэж үзэж байгаа тухай тайлбар;
 - Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн санхүүгийн байгууллагаас хүсэж байгаа арга хэмжээ;
 - Гарын үсэг.
3. Банк, санхүүгийн зохицуулагч байгууллагад мэдэгдэх
Хуулийн байгууллагад хандах

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2019/02/28-ний хооронд 835,0 сая ам.долларын болон 112.4 сая юанийн нийт 980 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



ХОЁРДУГААР САРД 84.1 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ




График 2. 2019 оны 2 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ



Монголбанкны Эрдэнэсийн сан 2019 оны 2 дугаар сард 84.1 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 438.6 кг алт худалдан авч байснаас 354.5 кг дутуу буюу 81%-иар буурсан үзүүлэлттэй байна. Мөн хугацаанд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 9.5 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 2.3 кг алтыг худалдаж авлаа. 2019 оны 2 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 111,748.31 төгрөг байлаа.

“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /Mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081